Тиймээс цаашид эрчим хүчний салбарын үнэ тарифыг бодит өртгөө нөхдөг байх зарчимд шилжүүлж хувийн хэвшлийн аж ахуйн нэгж тус салбарт хөрөнгө

оруулалт хийх боломжийг бүрдүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд олон жил хуримтлагдсан суурь үнэ тарифыг өөрчилж, цаашид алдагдал болон өр төлбөр хуримтлуулдаг бус өрсөлдөөнийг бий болгож, салбарт хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэл хийх боломжийг бий болгох үүднээс тус салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх зорилгоор эрчим хүчний салбарт шинэчлэл хийх шилжилтийн үеийн зардлыг санхүүжүүлэхэд зориулж 131.1 тэрбум төгрөг хуваарилахаар тооцов.

Шилжилтийн хугацаанд хэрэгжүүлэх цогц арга хэмжээний үр дүнд бүсүүд дэх эрчим хүчний бие даасан аж ахуйн нэгжүүлийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж нэгдсэн сүлжээний хүрээнд алдагдалгүй ажиллаж эхлэх бөгөөд 2025 оноос эхлэн улсын төсвөөс эрчим хүчний алдагдлын татаас олгохгүй байхаар тооцож байна.

Гучин жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын реформыг цаг алдалгүй эхлүүлснээр эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аж үйлдвэржилт, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх мега төслүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Цаашлаад сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, устөрөгч, метан хий, цөмийн эрчим хүч зэрэг шинэ технологи ашиглах чиглэлээр бодлогын дэмжлэг үзүүлж эрчим хүч экспортлогч улс болох томоохон зорилт тавьж байна

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв хооронд зохицуулалт хийнэ

Монгол Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох хууль, тогтоомжийн төслийг хэлэлцэн баталсан.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдаж, зарим яамдын эрхлэх асуудал, чиг үүрэгт өөрчлөлт орсон тул шинэ бүтцийг дагалдуулан чиг үүрэг хэрэгжүүлэх төсвийг шилжүүлэх өөрчлөлтийг тусгалаа. Үүнд: Залуучуудын хөгжлийг дэмжих бодлого, аялал жуулчлалын бодлого, биеийн тамир, спортын хөгжлийн бодлогын асуудлыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын чиг үүрэгт, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудлыг Эдийн засаг, хөгжлийн сайдын чиг үүрэгт, чөлөөт бүсийн хөгжлийн асуудлыг Монгол Улсын Шадар сайдын чиг үүрэгт тус тус шилжүүлсэн.

Мөн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга төсвийн ерөнхийлөн захирагчийг шинээр байгуулж, Монгол Улсын Шадар сайдын чиг үүрэгт төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хөрөнгө оруулалт, гадаад

худалдаа, шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудлыг, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын чиг үүрэгт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах асуудлыг тус тус нэмж тусгалаа.

2.2.2. Нийслэл Улаанбаатар хотын төсвийн суурь зарлага

Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар 500.0 сая ам.долларын нийслэлийн гадаад үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалах шийдвэр гарсан.

Нийслэл хотын нутаг дэвсгэр жилээс жилд тэлсээр байгаа боловч гэр хороолол нь төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдоогүй, нийгэм, соёлын үйлчилгээнээс алслагдсан зэрэг нийтлэг шинж чанар нь хотын байгаль экологи, хүн амын хөгжилд олон талын сөрөг нөлөөг үзүүлж байна. Иймээс “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, нийслэлийн дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн 3 үе шаттайгаар Сэлбэ дэд төв орчмын 158 га газрыг оновчтой зохион байгуулан хөгжүүлж, 12,000 айлын орон сууц, 960 хүүхдийн 3 сургууль, 240 хүүхдийн 5 цэцэрлэг, спорт цогцолбор, соёл олон нийтийн төв, эмнэлэг, хорооны цогцолбор барилга байгууламж, салбар шугам, авто зам, явган зам, ногоон байгууламж, тохижилтын бүтээн байгуулалтыг хийхээр төлөвлөн шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал, түүнчлэн төслийн талбайд хамрагдаж байгаа 2,206 нэгж талбарыг чөлөөлөхөд шаардлагатай нөхөн олговрын зардлыг нийслэлийн төсвийн суурь зарлагад тус тус нэмж тусгалаа.

2.3. Болзошгүй өр төлбөр

Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас өрийн удирдлагын оновчтой шийдвэр гаргаж, зээлийн эргэн төлөлтийг эрчимтэй хийлгэснээр хугацаа тулаад байсан Засгийн газрын өрийн баталгаат “Самурай” бондын 30 тэрбум иений төлбөрийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны өөрийн хөрөнгөөр төлж барагдуулсан болно.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 133 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Хөгжлийн банкны 420 сая юанийн зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд зориулж Монгол Улсын Хөгжлийн банканд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд тус дулааны

цахилгаан станцын өргөтгөл нь 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ашиглалтад орсон. Уг зээлийн эргэн төлөлт 2031 онд төлөгдөж дуусах хуваарьтай байна.

Ийнхүү 2023 онд Засгийн газрын өрийн баталгаат үнэт цаасыг төлж барагдуулснаар болзошгүй өр төлбөрийн хүрээнд 2031 он хүртэл томоохон эрсдэлгүй болоод байна.

Цаашлаад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 201 дугаар тогтоол болон 06 дугаар сарын 06-ны өдрийн 264 дүгээр тогтоолын дагуу 2024 онд дотоодын зах зээлд 1.0 их наяд төгрөгийн үнэт цаасыг арилжаалж “Бөөрөлжүүтийн ДЦС”, “Батарей хуримтлуурын станц”, “Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил”, “Ариутгах Бохир усны Туул-1 коллектор болон үерийн байгууламж” зэрэг төслүүдийг санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна. Үүнээс эхний ээлжид 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр 500 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан болно.

Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.1} дэх хэсэгт нийслэлийн гадаад үнэт цаасыг Засгийн газрын өрийн баталгаатай гаргаж болохоор заасан бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоол болон Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 265 дугаар тогтоолоор нийслэлийн 500 сая ам.долларын гадаад үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгосон болно.

ХАВСРАЛТ. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

Төсвийн тухай хуульд 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр жилийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг олон нийтэд хэлэлцүүлж, хэлэлцүүлгээс гарсан шаардлага хангасан саналыг төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгах эрх зүйн зохицуулалттай болсон.

Төсвийн тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.2}-г зааснаар төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд зохион байгуулна гэсний дагуу 2024 оны төсвийн тодотголын төсөлтэй холбоотой саналыг Сангийн яамны цахим хуудсаар дамжуулан 2024 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс 8 дугаар сарын 5-ны өдрийг дуустал цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Цахим хэлэлцүүлгийн үр дүнд ямар нэгэн санал ирүүлээгүй байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2024 он

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ	3
БҮЛЭГ 1. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ	6
1.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	6
1.2. Монгол Улсын макро эдийн засгийн хагас жилийн гүйцэтгэл	7
1.3. Монгол Улсын эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	10
1.4. Түүхий эдийн үнийн зах зээлийн хандлага	11
1.5. Эдийн засаг болон төсвийн төсөөлөлд учирч болзошгүй бусад эрсдэл	13
1.6. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэл болон хүлээгдэж байгаа гүйцэтгэл	14
1.6.1. Төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэл	14
1.6.2. Төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл	15
1.7. Төсвийн урсгал зарлагын хүлээгдэж байгаа гүйцэтгэл	16
1.8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар	16
1.9. Засгийн газрын гадаад зээл, тусламж	17
1.10. Засгийн газрын өр	18
БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ	21
2.1. “Хурдтай хөгжлийн төлөөх зориг”-Шинэ 30 жилийн хөгжилд чиглэсэн төсвийн бодлого	21
2.2. Хөгжлийн бүтээн байгуулалтыг дэмжих “Төсвийн дүрэм”	23
2.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв хооронд зохицуулалт хийх	24
БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ	25
3.1. Хөгжлийн хөрөнгө оруулалт	25
3.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт	25
3.1.2. Гадаад зээл тусламжаар хэрэгжих хөгжлийн бүтээн байгуулалтууд:	31
3.2. Төсвийн урсгал зардал	37
3.2.1. Улсын төсвийн урсгал зарлага	37
3.2.2. Нийслэл Улаанбаатар хотын төсвийн суурь зарлага	40
3.3. Болзошгүй өр төлбөр	40
БҮЛЭГ 4. ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСЛИЙН ХАВСРАЛТ	42
4.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд	42
4.2. Төсвийн тусгай шаардлага	42
4.3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тайлбар 43	
4.4. Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн	45

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудын хувь нэмэр (хувь)	7
Хүснэгт 2. 2024 оны эхний 6 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	15
Хүснэгт 3. 2024 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (тэрбум төгрөг)	15
Хүснэгт 4. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	17
Хүснэгт 5. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг).....	18
Хүснэгт 6. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)	19
Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг).....	42
Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	42
Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь	43
Хүснэгт 10. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)	43

ЗУРАГ

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирлаар (хувь).....	7
Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь).....	8
Зураг 3. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)	9
Зураг 4. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)	10
Зураг 5. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	12
Зураг 6. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/трой унц).....	12
Зураг 7. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	12
Зураг 8. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	12
Зураг 9. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)	13
Зураг 10. Улсын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг).....	16
Зураг 11. Ган татлагат гүүрэн байгууламж	25
Зураг 12. Гүүрэн байгууламж	26
Зураг 13. Хөшигийн хөндийн туннел	26
Зураг 14. Хөшигийн хөндийн туннел	26
Зураг 15. Шинэ тойрог авто зам.....	27
Зураг 16. Шинэ тойрог авто зам.....	27
Зураг 17. Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор	27
Зураг 18. Туул хурдны авто зам	28
Зураг 19. Туул хурдны авто зам	28
Зураг 20. Бүсийн хөгжил.....	29
Зураг 21. Шинэ Хархорум хот.....	30
Зураг 22. Хиймэл дагуулын төслийн загвар зураг.....	31
Зураг 23. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц	32
Зураг 24. Газрын тос боловсруулах үйлдвэр.....	32
Зураг 25. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын зураг	33
Зураг 26. Солонго I хороолол	33
Зураг 27. Улаанбаатар-Дархан чиглэлийн 4 эгнээ зам	34
Зураг 28. Хөтөлбөрийн байршлын зураг	35
Зураг 29. Орлогод нийцсэн ногоон орон сууцны хороолол	35
Зураг 30. Говьсүмбэр аймгийн төвийн дулааны станцын барилга, угсралтын ажил	36
Зураг 31. Дулаан хангамжийн шугам сүлжээний шинэчлэлийн ажил	37

ӨМНӨТГӨЛ

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөлөө арилж, улс орнуудын мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр инфляц саарсан нь ажил эрхлэлт, өрхийн хэрэглээг дэмжиж, дэлхийн эдийн засаг 2023 онд 3.3 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн өсөлтийг Олон улсын валютын сан 2024 онд 3.2 хувь, 2025 онд 3.3 хувь орчимд тогтвортой байхаар тооцож байна. Инфляцын бууралт нь мөнгөний бодлогыг сулруулж, эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр байна.

Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын эдийн засгийн идэвхжил хүлээлтээс давж 2023 онд 5.0 хувиар өсөж, 2024 оны эхний хагаст ч энэ төлөв хадгалагдаж байгаа нь цаашид бүс нутгийн өсөлт тогтвортой хадгалагдана гэж шинжээчид үзэж байна. БНХАУ-ын эдийн засаг 2023 онд Засгийн газрын зорилтот 5.0 хувийн өсөлтийг давж, 5.2 хувиар өссөн. Гэвч БНХАУ-ын эдийн засагт үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж эдийн засгийн өсөлтийг сааруулж байгаа нь бүс нутгийн эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Манай улсын хувьд уул уурхайн салбарын экспортын сэргэлт 2023 онд үргэлжилж, төсөв, төлбөрийн тэнцэл түүхэнд байгаагүй ашигтай гарсан нь эдийн засаг 7.4 хувиар өсөх нөхцөл болсон. 2024 оны эхний улирлын байдлаар эдийн засаг 7.8 хувиар өссөн ба энэ онд уул уурхайн салбарын сэргэлт үргэлжилж 5.6 хувиар өсөх төлөвтэй байна.

Импортын инфляцын нийт инфляцад үзүүлэх нөлөө 2023 оноос алгуур буурч тогтворжсоноор инфляцын түвшин саарч, 2024 оны 6 дугаар сард 5.1 хувь буюу мөнгөний бодлогын зорилтот түвшинд хүрээд байна.

Олон улсын байгууллагууд манай улсын эдийн засгийг дунд хугацаанд 6-8 хувиар өсөх төлөвтэй гэж үзэж байгаа ч дэлхийн болон бүсийн эдийн засагт үүсээд буй тодорхой бус байдлаас шалтгаалсан уул уурхайн голлох бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд нь манай улсад орох хөрөнгийн урсгал, гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг анхааруулж байна.

Эдгээр гадаад орчны тодорхой бус байдал, эрсдэлт цаг үед улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэхийн зэрэгцээ урт хугацааны хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх шаардлага үүслээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн дагуу сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн хамтарсан Засгийн газар байгуулагдаад байна. Энэ хүрээнд 3 намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилтод суурилсан “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” Хамтарсан Засгийн газрын гэрээ байгуулагдаж, хамтын ажиллагааны зарчим, хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон. Уг гэрээнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал,

сорилтыг шийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

Дээр дурдсан хөгжлийн асуудлуудыг дан ганц татварын орлогын эх үүсвэрээр шийдвэрлэх боломжгүй бөгөөд нэмэлтээр гадаад эх үүсвэртэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэх боломжтой юм. Тиймээс хамтарсан Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөгжлийг урагшлуулах томоохон төслүүдийг бодитой хэрэгжүүлэх зорилгоор нэгдсэн төсвийн зарлага, төсвийн тэнцэл, Засгийн газрын өрийн тусгай шаардлагын бүтэц, агуулгыг шинэчилж олон улсын жишигт нийцүүлэх тогтолцооны суурь реформыг эхлүүлнэ.

Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчит компанийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах, төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх тогтолцоог бүрдүүлж, уул уурхайн төрийн өмчит компаниудын засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, үр ашгийг дээшлүүлэх шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

Засгийн газраас эдийн засгийг багтаамжийг нэмэгдүүлэх, хөгжлийг урагшлуулах дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

Нэгдүгээрт, “ХУРДАЙ ХӨГЖИЛ”-ийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын томоохон бүтээн байгуулалт 1/ бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох “Шинэ сэргэлтийн таван тойрог” автозамын төсөл, Шинэ Хархорум төсөл, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг задалж төрийн байгууллагуудыг Хөшгийн хөндий рүү шилжүүлэх “20 минутын хот” төслийн хүрээнд хийгдэх Шинэ Зуунмод хот байгуулалтын төсөл, “Хөшгийн хөндийн туннелийн байгууламж”, “Өөдөө тэмүүлэх Монгол-Go Mongolia” ган татлагат гүүрэн байгууламж, “Шинэ тойрог зам”, “Туулын хурдны зам” болон “Төрийн байгууллагуудын нэгдсэн цогцолбор” төслүүд, 2/ эдийн засгийн бодлогын хүрээнд хийгдэх мега төслүүдийг тэтгэх эрчим хүчний реформ, түүнчлэн боомт, аялал жуулчлал, төмөр зам, дулааны болон усан цахилгаан станц, газрын тосны төслүүдийг хамтарсан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Хоёрдугаарт, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй Бүсчилсэн хөгжил, Шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг нэмэгдүүлнэ.

Шивээхүрэн-Сэхээ боомтын 6.9 км төмөр замын суурь бүтцийг 2024 онд барьснаар уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэн экспортлох хүчин чадал 10 сая тонноор нэмэгдүүлсэн. Харин цаашид нүүрсний экспортын зорилтыг хангах хүрээнд төмөр замын боомтын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлж, “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан холболтыг гүйцээснээр нүүрсний экспортын хүчин чадлыг жилдээ 30-50 сая тонноор нэмэгдүүлнэ.

Гуравдугаарт, Сүүлийн 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, бодит өртгөө нөхдөг байх зарчмыг баримталж, хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх үүднээс эрчим хүчний салбарын шинэчлэл шилжилтийн үеийн зардлыг тусгаж байна.

Дөрөвдүгээрт, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг шийдвэрлэж, Шинэ сэргэлтийн бодлогод туссан бүтээн байгуулалтыг төслүүдийг ирэх онуудын төсөвт тусгахаар тооцов.

Тавдугаарт, Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжуудад орсон өөрчлөлтийн дагуу зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон мөн зарим яам агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

Зургаадугаарт, Төсвийн тодотголын төсөлтэй хамт 13 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Дагалдах хууль тогтоомжийн төсөлд туссан онцлох өөрчлөлтийг дурдвал:

Монгол Улсад өмнө хэрэгжүүлж байгаагүй томоохон бүтээн байгуулалтын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг “Чадавхад суурилсан хэлэлцээний арга”-аар зохион байгуулахаар хуулийн төсөлд тусгалаа. Нэр хүнд бүхий аж ахуй нэгжийг түүний туршлага, санхүүгийн болон техникийн чадавхад үндэслэн урилгаар оролцуулж, хэлэлцээ хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Ингэснээр бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг шуурхай хэрэгжүүлэх боломж бий болгоно гэж үзэж байна.

Хувийн хэвшил нийгмийн хариуцлагын хүрээнд байгалийн нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, зохистой ашиглах, цөлжилтийг сааруулах, орчны бохирдлыг бууруулах, соёлын өвийг хамгаалах, сэргээх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, хамгааллын үйл ажиллагаа явуулах, боловсрол, шинжлэх ухааныг дэмжих чиглэлээр тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг олгох, биеийн тамир, спортын барилга байгууламж барьж, ашиглах зэрэг нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийг өөрийн хөрөнгөөр санаачлан хэрэгжүүлж, төрийн үүрэх ачааллыг хуваалцаж байгааг татварын бодлогоор дэмжих нь зүйтэй байна. Иймд хувийн хэвшил нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, санхүүгийн дэмжлэг үзүүлбэл борлуулалтын орлогын 1 хүртэл хувийн татварын хөнгөлөлт үзүүлэхээр тус тус хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

Шинэ 30 жилийн хөгжлийн загварт нийцсэн төсвийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хадгалах төсвийн шинэчлэл нь “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан Бүсчилсэн хөгжлийн бодлого, Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын тэргүүлэх чиглэл, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эхний шат болох ба ингэснээр эдийн засгийн өсөлтийг 5 ба түүнээс дээш хувьд, инфляцыг 5 хувьд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах, улмаар Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд тавьсан хөгжлийн зорилтуудыг хангах нөхцөл бүрдэх юм.

БҮЛЭГ 1. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ

1.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Дэлхий дахиныг хамарсан цар тахал, геополитикийн тогтворгүй байдал, тэдгээрээс үүдэлтэй тээвэр, логистикийн саатал, үнийн өсөлт болон мөнгөний хатуу бодлогын нөлөө үргэлжилсэн ч ажил эрхлэлт, өрхийн орлого сайжирч, нийт эрэлтийг дэмжсэнээр дэлхийн эдийн засаг 2023 онд 3.3 хувиар өслөө. Олон улсын валютын сангийн төсөөллөөр Дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 онд 3.2 хувиар өсөхөөр хүлээгдэж байна. Инфляцын бууралт мөнгөний бодлогын төлөвийг сулруулах орон зайг бий болгож, эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр байна.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засаг 2024 оны 2 дугаар улиралд 4.7 хувиар өслөө. Тус улсын үл хөдлөх салбарын хямрал үргэлжилж байгаа нь дэлхийн эдийн засаг, худалдааны эргэлт, түүхий эдийн эрэлт, үнэд томоохон эрсдэлийг бий болгож байна. 2024 оны эхний 6 сарын байдлаар үл хөдлөх салбарын хөрөнгө оруулалт 10.1 хувиар, борлуулалт 19.0 хувиар тус тус буурснаар салбарын эмзэг байдал илэрч байгаа ба Засгийн газар, Хятадын ардын банкнаас эдийн засгийн идэвхжилийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээний цар хүрээг хэрхэн тэлэх нь тус улсын эдийн засгийн төлөвийг тодорхойлохоор байна. Олон улсын валютын сан тус улсын эдийн засгийн 2024 оны өсөлтийн төсөөллийг 5.0 хувь байхаар төсөөлж байна.

ОХУ: ОХУ-ын эдийн засаг 2024 оны эхний улиралд 5.4 хувиар өссөн ба уг өсөлтөд Украинд болж буй дайнтай холбоотой цэрэг армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн тэлэлт голлон нөлөөллөө. Цаашид дайнтай холбоотойгоор ОХУ-ын эдийн засагт тогтворгүй байдал үргэлжлэх төлөвтэй байгаа тул тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд 3.2 хувь, 2025 онд 1.5 хувь орчимд байна гэж тооцож байна.

АНУ: Хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 2.8 хувьд хүрч эрчимжлээ. 2022 оны 6 дугаар сард 9.1 хувьд хүрээд байсан инфляц 2024 оны 6 дугаар сард 3 хувь болж буурч, үнийн өсөлт саарах хандлага ажиглагдаж байгаа нь бодлогын хүү буурах хүлээлтийг нэмэгдүүлж байна. Тус улсын эдийн засаг 2024 онд 2.6 хувиар өсөх хүлээлттэй байна.

Евро бүс: Инфляцыг хязгаарлахаар хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа суларч, евро бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд хүлээлтээс доогуур буюу 0.4 хувь байлаа. Инфляцын дарамт буурсантай холбоотойгоор Европын төв банк бодлогын хүүг 2024 оны 6 дугаар сард 2019 оноос хойш анх удаа бууруулаад байна.

Хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт болон мөнгөний бодлогын нөлөөгөөр тус бүсийн эдийн засаг 2024 онд 0.9 хувиар өсөх хүлээлттэй байна.

1.2. Монгол Улсын макро эдийн засгийн хагас жилийн гүйцэтгэл


Дотоодын нийт бүтээгдэхүүн: Нэрлэсэн ДНБ 2024 оны эхний улиралд 16.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 6.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр орууллаа.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудын хувь нэмэр (хувь)

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024.I
ДНБ	-4.6	1.6	5.0	7.4	7.8
ХАА	0.8	-0.8	1.7	-1.3	-1.3
Үйлдвэрлэл	-1.3	-0.6	-1.2	3.2	2.8
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.9
Боловсруулах	0.3	-0.1	0.5	0.4	0.4
Цахилгаан, ус	0.0	0.2	0.1	0.1	0.3
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.2
Үйлчилгээ	-3.0	1.8	3.2	4.7	4.2
Худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.7
Тээвэр	-1.0	-0.3	0.4	1.8	1.3
Бусад	-0.6	1.5	1.7	2.1	2.2
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирлаар (хувь)



Уул уурхайн салбар 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 13 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.9 нэгж хувийг бүрдүүллээ. Үүнд нүүрс олборлолт 22 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 25 хувиар, төмрийн хүдэр олборлолт 1.5 сая тоннд хүрч 63 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөлөв. Харин зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеийн түвшинтэй ойролцоо байгаа бол алт болон газрын тос олборлолт

харгалзан 5 болон 10 хувиар тус тус буурсан байна. Түүнчлэн, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэр болон бараа, бүтээгдэхүүний импорт өссөнөөр ачаа тээвэр 2024 оны эхний улиралд 34.3 сая тоннд хүрч, тээврийн салбарын үйлдвэрлэл 27 хувиар тэлэв.

Инженерийн дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтуудын нөлөөгөөр барилгын салбар 2024 оны эхний улиралд 27.7 хувиар өссөн бол хүнсний зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбар 6.3 хувиар тэллээ.


Энэ оны эхний улиралд дотоодын эдийн засгийн идэвхжил, өрхийн бодит орлого нэмэгдсэнээр үйлчилгээний салбарын дийлэнхийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.5 хувиар өсөв. Өрхийн хүнсний бус хэрэглээний зардал, хэрэглээний импорт нэмэгдэж, хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа 19 хувиар өссөн нь нийт худалдааны борлуулалтад эергээр нөлөөлжээ. Мөн мэдээлэл, холбооны салбар 26.3 хувиар, үйлчилгээний бусад салбаруудын гарц 3.7 хувиар тэлсэн байна.

Харин том малын зүй бус хорогдол 2024 оны эхний улиралд 6.3 сая толгойд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдсэнээр хөдөө аж ахуйн салбар өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 1.3 нэгж хувиар хязгаарлалаа.

Инфляц: Улсын жилийн инфляц 2024 оны 6 дугаар сард 5.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурлаа. Инфляцын бууралтын 3.7 нэгж хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 0.7 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутал, 0.2 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 0.3 нэгж хувийг гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа, 0.3 нэгж хувийг тээвэр, 0.5 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээ тус тус бүрдүүлсэн байна.

Импортын инфляцын нийт инфляцад үзүүлэх нөлөө 2023 оноос эхлэн алгуур буурч тогтворжоод байна. Тухайлбал, 2024 оны 6 дугаар сард импортын барааны үнийн өсөлт нийт инфляцын 1.8 нэгж хувь буюу 35.3 хувийг эзэллээ. Импортын инфляц буурахад төгрөгийн ханш тогтворжсон, гадаад үнэ буурсан болон цар тахлаас үүдэлтэй тээвэр логиستيкийн саатал арилсан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлөв.

Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дотоодын бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 6 дугаар сард 6.1 хувиар өсөж, нийт инфляцын 3.3 нэгж хувийг бүрдүүллээ. Дотоодын хүнсний үнийн өсөлт саарч, жилийн 4.7 хувиар өссөн нь нийт инфляцын 1.4 нэгж хувийг бүрдүүлж байна. Мөн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт саарч, жилийн 6.8 хувиар өссөн нь нийт инфляцын 1.5 нэгж хувийг бүрдүүлэв. Үйлчилгээний бүлгийн инфляцад боловсролын үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард 16.8 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 6 дугаар сарын байдлаар 41.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар өслөө.


Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр талаас (пассив) төгрөгийн харилцах, хадгаламж нийлбэр дүнгээрээ өмнөх оны мөн үеэс 39.2 хувиар өсөж, нийт өсөлтийн 27.2 нэгж хувийг бүрдүүлжээ. Харин байршуулалт талаас (актив) гадаад цэвэр актив нэмэгдсэн болон зээл олголт өссөн нь мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд голлох нөлөөг үзүүлэв.

Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Эдийн засгийн өсөлт хөдөлмөрийн зах зээлд эергээр нөлөөлж ажиллах хүчний оролцооны түвшин 2024 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсөж 59.4 хувьд хүрлээ. Гэсэн хэдий ч цар тахлын өмнөх үеэс 1.2 нэгж хувиар бага байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өссөнөөр 56.3 хувьд хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 1.6 нэгж хувиар өндөр үзүүлэлттэй байна.

Ажиллагсдын тооны хувьд 2024 оны эхний улирлын байдлаар 1 сая 294 мянга болж өмнөх оны мөн үеэс 37.8 мянган хүнээр, цар тахлын өмнөх үеэс 150 мянган хүнээр тус тус нэмэгджээ. Ажиллагсдыг салбараар харвал худалдаа, үйлчилгээ, уул уурхай, тээвэр, цахилгааны салбарын ажилчид өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байгаа бол өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбарын ажилчдын тоо буурсан байна.

Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 5.6 мянган хүнээр, цар тахлын өмнөх үеэс 11.7 мянган хүнээр тус тус буурч 71 мянгад хүрлээ. Хот, хөдөөгөөр ангилан харвал Улаанбаатар хотод хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн тоо 74 мянган хүнээр нэмэгдэж, ажилгүй иргэдийн тоо 15 мянган хүнээр буурсан бол хөдөөд ажиллагчдын тоо 9 мянган хүнээр буурч, ажилгүй иргэдийн тоо мөн 9 мянган хүнээр нэмэгдсэн байна.

Зураг 3. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



Төлбөрийн тэнцэл: Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 6 сард 57 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Барааны импорт өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум ам.доллаароор өссөнөөр урсгал данс 530 сая ам.долларын алдагдалтай гарсан бол гадаад бондын төлбөр болон худалдааны зээлтэй холбоотой гадаад валютын гарах урсгал буурснаар санхүүгийн данс 721 сая ам.долларын ашигтай гарлаа. Засгийн газар 2024 оны 3 дугаар сард Хуралдай бондын үлдэгдэл өр төлбөрийг бүрэн төлж барагдууллаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын албан нөөц 2024 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 4.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 0.9 тэрбум ам.доллаароор нэмэгдлээ.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 6 сарын байдлаар 13.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар өссөн бол худалдааны тэнцэл 2.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 7.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсөв.

Уурхайн хяналт шалгалтын улмаас БНХАУ-ын коксжих нүүрсний дотоод үйлдвэрлэл буурч, импорт нэмэгдсэн нь манай улсын коксжих нүүрсний экспортыг тэтгэж, Монгол Улс 2024 оны эхний 6 сард 40.6 сая тонн нүүрс экспортолж, нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 38 хувиар нэмэгдлээ. Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлсэн, төмөр замын тээвэр зохион байгуулалтыг сайжруулсан зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспорт 2024 оны эхний 6 сард 785


мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар, төмрийн хүдрийн экспорт 3,596 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 34 хувиар тус тус нэмэгдлээ. Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 оны эхний 6 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 57 хувиар, ноосны экспорт 45 хувиар, арьс ширний экспорт 31 хувиар тус тус буурлаа.

Импорт 2024 оны эхний 6 сард 5.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 25.9 хувь буюу 1.1 тэрбум ам.доллараар нэмэгдлээ. Зээл олголт, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр тоног төхөөрөмжийн импорт өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар өссөн нь импортын өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Мөн өрхийн бодит орлого болон иргэдийн хэрэглээний зээл өссөнөөр худалдан авах чадвар сайжирч, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт 22.7 хувиар өссөн ба тэр дундаа автомашины импортын өсөлт өндөр байна.

1.3. Монгол Улсын эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 5.6 орчим хувь байхаар төсөөлж байна. Оюутолгойн гүний уурхайн олборлолт үргэлжилснээр баяжмал дахь зэс болон алтны агууламж нэмэгдэхийн зэрэгцээ нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байна. Уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээвэр өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр 2024 оны сүүлийн хагас жилд аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлттэй байна. 2022 онд батлагдсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах тоног төхөөрөмжийн импортын татварыг тэглэснээр 2023 онд тоног төхөөрөмжийн импорт нэмэгдсэн нөлөөгөөр 2024 онд боловсруулах салбарын гарц

Зураг 4. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.долларт)



нэмэгдэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшихаар байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ өсөж, дотоод эрэлт сайжран, улмаар худалдаа, үйлчилгээний борлуулалт нэмэгдэн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны жилийн эцэст 27.9 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд нүүрсний экспорт 78.1 сая тоннд хүрч, нийт экспортын дүн 2024 оны эцэст 16.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Харин өрхийн орлого, зээл олголт нэмэгдэж, эдийн засгийн өсөлт тогтвортой байснаар импорт 2024 оны эцэст 11.3 тэрбум ам.долларт хүрч өсөхөөр байна.

Засгийн газраас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн экспортын биет хэмжээний өсөлтийн нөлөөгөөр 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарахаар хүлээгдэж байна.

Улсын инфляц 2024 оны эцэст төв банкны зорилтот түвшний дээд интервал орчимд байхаар хүлээгдэж байна. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 8.1 сая толгой мал хорогдсон нь ирэх онуудад махны нийлүүлэлт буурч, үнэ өсөх эрсдэлийг нэмэгдүүллээ. Мөн Тяньжин боомт дээрх чингэлгийн тоо хэвийн үеийнхээс давж 2024 оны 7 дугаар сарын байдлаар 5,800 орчим болсон нь импортын барааны нийлүүлэлт тасалдаж, үнэ өсөх эрсдэлийг дагуулж байна.

1.4. Түүхий эдийн үнийн зах зээлийн хандлага

Зэс: Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн 2024 оны эхний хоёр улирлын дундаж үнэ 9,094 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар өссөн байна. Дэлхийн томоохон зэсийн ил уурхайнуудын нэг болох “Cobre mine Panama” хаагдсан, Их Британийн уул уурхайн үндэстэн дамнасан Anglo American компани зардлаа танаж, зэсийн үйлдвэрлэлээ бууруулахаа мэдэгдсэн нь богино хугацаанд нийлүүлэлтийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөлж байна. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр зэсийн эрэлт дунд хугацаанд нэмэгдэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2024 онд 9,500 ам.долларт хүрэхээр байна.


Алт: Алтны 2024 оны эхний хоёр улирлын дундаж үнэ 2,206 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар өслөө. Геополитикийн хурцадмал байдал нэмэгдэж байгаа нь алтны эрэлт болон үнэ өсөхөд нөлөөлж байна. Дэлхийн банкны үзэж

байгаагаар дунд хугацаанд дэлхийн эдийн засаг тогтворжиж, алтны эрэлт бага зэрэг сулрах хүлээлттэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2024 онд 2,200 ам.долларт хүрэхээр байна.




Эх сурвалж: Блүүмберг терминал

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) 2024 оны эхний хоёр улирлын дундаж үнэ 118 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 15 хувиар буурсан байна. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сул хэвээр байгаа, Австрали Улс шинэ уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Бразил Улс нийлүүлэлтээ жил бүр 6 хувиар нэмэгдүүлэхээ зарласан нь үнэ буурахад голлон нөлөөллөө. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2024 онд 120 ам.долларт хүрэхээр байна.



Эх сурвалж: Блүүмберг терминал


Коксжих нүүрс: Сингапурын бирж дээрх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний хоёр улирлын дундаж үнэ 278 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 19 хувиар буурсан байна. Байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан саатаад байсан Австралийн коксжих нүүрсний олборлолт хэвийн болж, нийлүүлэлт тогтворжсон нь үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ коксжих нүүрсний татварыг сэргээсэн нь эрэлтийг бууруулахаар байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 250 ам.долларт хүрэхээр байна.



Эх сурвалж: Блүүмберг терминал

Газрын тос: Брент төрлийн газрын тосны 2024 оны эхний хоёр улирлын дундаж үнэ 82 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 6 хувиар өслөө. ОПЕК-ийн орнууд өнгөрсөн оны 6 дугаар сард 2024 онд олборлох газрын тосны хэмжээг бууруулахаар шийдвэрлэснээс гадна нефть, газрын тосны олборлолтын 35 орчим хувийг бүрдүүлдэг Ойрх дорнод дахь мөргөлдөөн нь газрын тосны нийлүүлэлтийн тогтворгүй байдлыг бий болгож, үнэ өсөж байна. Түүнчлэн, алт болон газрын тосны томоохон хэрэглэгч Бүгд Найрамдах Энэтхэг Улсын эдийн засгийн идэвхжил газрын тосны эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 80 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 9. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)



1.5. Эдийн засаг болон төсвийн төсөөлөлд учирч болзошгүй бусад эрсдэл

Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тодорхой бус байдал, эрчим хүчний дутагдал болон уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл нь төсөвт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Түүхий эдийн эрэлт, үнэ буурах: Манай экспортын бүтээгдэхүүний гол худалдан авагч болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарт уналт үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг сааруулах томоохон хүчин зүйл хэвээр байх эрсдэлтэй байна. Засгийн газраас тус салбарын уналтын эсрэг бодлогын арга хэмжээг удаа дараалан хэрэгжүүлж байгаа ч, дотоодын эрэлт хангалтгүй байгаагаас шалтгаалан орон сууцны үнэ, орон сууц борлуулалт, үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт үргэлжлэн буурсаар байна. Үл хөдлөх хөрөнгө болон барилгын салбар нь БНХАУ-ын гангийн хэрэглээний 50 гаруй хувийг эзэлдэг энэхүү бууралт нь гангийн эрэлтэд цаашлаад бүтээгдэхүүний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Ингэснээр дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрс зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлтэй байна.

Нэг. Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах: ОХУ-Украины дайн, Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөн, БНХАУ-Тайваний сөргөлдөөн зэрэг геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилсэн хэвээр байгаа нь түүхий эдийн үнэ хэлбэлзэх, үнийн өсөлт үргэлжлэх эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн АНУ зэрэг бусад өндөр хөгжилтэй улс орнуудад үйлчилгээний салбарын инфляц

өндөр хэвээр байгаа нь бодлогын хүүг бууруулахгүй байх нөхцөл бүрдүүлж байна. Мөнгөний хатуу бодлого үргэлжилснээр олон улсын санхүүгийн зах зээл тогтворгүй байдалд орж дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж болзошгүй юм. Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарах, түүхий эдийн үнийн тогтворгүй байдал үүсэх нь манай улсад орох хөрөнгийн урсгалыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Хоёр. Малын өвчин, цаг агаар, ган зудын эрсдэл: Хөдөө аж ахуйн салбар нь байгаль, цаг уурын нөхцөл байдалтай шууд хамааралтай. Энэ онд өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас эхний хагас жилийн байдлаар том малын зүй бус хорогдол 8.1 сая буюу нийт малын 13 хувьд хүрээд байна. Улмаар хөдөө аж ахуйн салбарын нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, өрхүүдийн бодит орлогыг бууруулах, тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэл байна. Мөн хөдөөгийн өрхийн орлогын 38.7 хувийг мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого бүрдүүлдэг бөгөөд малын хорогдол өндөр байгаа нь өрхийн орлогыг бууруулж, ажилгүйдлийн түвшин, тэгш бус байдал, Засгийн газрын зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Гурав. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг: Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед зээлжих зэрэглэл буурах, аливаа төрлийн хоригт өртөхгүй байх нь чухал байна. Иймд, манай улс олон улсад баримталж буй дүрэм журмуудыг сайтар мөрдөж, харилцан ойлголцож, зээлжих зэрэглэл тогтоох болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх шаардлагатай. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

1.6. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэл болон хүлээгдэж байгаа гүйцэтгэл

1.6.1. Төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэл

Монгол Улсын Засгийн газар экспортыг эрчимжүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалах хүрээнд шат дараалсан бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр цаг үеийн шинжтэй шийдвэрийг шуурхай гаргаж хэрэгжүүлсний үр дүнд 2020 онд 4.6 хувиар агшаад байсан эдийн засаг 2023 онд 7.0 хувийн өсөлттэй гарлаа. Мөн 16 сая тонн болж уналтад ороод байсан нүүрсний экспорт 2023 онд 69.6 сая тоннд хүрч түүхэн дээд амжилт тогтоосон. Эдгээр бодлогын нөлөөгөөр төсвийн орлогын төлөвлөгөө сүүлийн 4 жил тасралтгүй давж биеллээ.

2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 14,947.1 тэрбум төгрөгт хүрч, жилийн батлагдсан дүнтэй харьцуулахад 54 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. 2024 оны эхний 6 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.06 ГҮЙЦ	2024.06 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт орлого	11,059.3	14,947.2	3,887.8
Тогтворжуулалтын сан	477.9	220.7	-257.3
Тэнцвэржүүлсэн орлого	10,581.3	14,198.8	3,617.5
Татварын орлого	9,841.2	13,291.0	3,449.8
Татварын бус орлого	740.1	907.8	167.7

Эхний хагас жилийн орлогын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үеийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 3,887.9 тэрбум төгрөгөөр буюу 35.2 хувиар өсжээ. Үүнд, эдийн засаг идэвхжиж, гадаад худалдааны эргэлт сайжирч, нүүрсний экспорт 40.6 сая тоннд хүрч, улмаар уул уурхай болон тээвэр, үйлчилгээний салбарын орлого өсөж, үүнээс улбаалан аж ахуйн нэгжүүдийн борлуулалт сайжирсан нь голлон нөлөөлсөн байна.

1.6.2. Төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Макро эдийн засгийн нөхцөл байдал, үндсэн үзүүлэлтүүд, энэ оны эхний хагас жилийн орлогын гүйцэтгэлд үндэслэн 2024 оны нэгдсэн төсвийн орлогыг шинэчлэн тооцлоо. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлого 30,639.5 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан дүнгээс 2,917.4 тэрбум төгрөгөөр, тэнцвэржүүлсэн орлого 28,872.5 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан дүнгээс 3,017.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

Хүснэгт 3. 2024 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 БАТ	2024 ХБГ	ЗӨРҮҮ
Тэнцвэржүүлсэн орлого	25,855.1	28,872.5	3,017.3

Засгийн газар төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр худалдааны эргэлт, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах боломжтой. Хилийн боомтын нэвтрэх чадварыг сайжруулах, хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлснээр энэ онд нүүрсний экспортыг түүхэн дээд хэмжээнд буюу 78.1 сая тонн хүргэх зорилт тавин ажиллана. Ингэснээр уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх орлого 9 орчим их наяд төгрөгт хүрнэ гэж тооцлоо.

Цаашид 2024 онд төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

- ✓ Уул уурхайн бүтээгдэхүүний ил тод, нээлттэй худалдааг үргэлжлүүлэн хөгжүүлэх, боловсронгуй болгох зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана;
- ✓ Гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, голлох хилийн боомтын хүчин чадал, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ;
- ✓ Татварын ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр татварын бүртгэл, хураалтыг сайжруулан, далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг өргөжүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.


1.7. Төсвийн урсгал зарлагын хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Төсвийн нийт урсгал зардал 2024 онд 22.4 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 59.4 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 16.9 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 14.4 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 5.3 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр 4.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

1.8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2024 онд 13.8 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2018-2023 онд 9.6 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэн бол 2024 онд 3.3 их наяд төгрөг батлагдсан.

Зураг 10. Улсын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)



Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 1299 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 3,359.4 тэрбум төгрөг, концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслийн эргэн төлөлтөд 1 төсөл, арга хэмжээнд 25.0 тэрбум төгрөг, 2024.08.11-ний өдрийн байдлаар гүйцэтгэл 23.6% буюу 800.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2024 онд 13.8 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2018-2023 онд 9.6 наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэн бол 2024 онд 3.3 их наяд төгрөг батлагдсан.

Түүнчлэн, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 409 дүгээр тогтоолоор 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 29%-ийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, 25%-ийг төсвийн ерөнхийлөн захирагч нар, 45%-ийг аймгийн Засаг дарга нар тус тус хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд барилга, байгууламжийн 1020 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Тухайлбал, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын байгууллагын барилга байгууламж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 19.7 мянган ор бүхий 149 цэцэрлэг, 60,000 орчим суудал бүхий 156 сургууль, 1700 ор бүхий 19 дотуур байр, эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний барилга байгууламж, хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 3000 орчим ор бүхий 43 эмнэлэг, орон нутгийн иргэдийг соён гэгээрүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зориулалт бүхий барилга байгууламжийн чиглэлээр 63 соёлын төв, бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих, сум, сууриныг холбох болон доторх авто замын хүчин чадлыг сайжруулах дэд бүтцийг нэмэгдүүлэх чиглэлээр 1,883.2 километр бүхий 106 зам, гүүрний барилга, эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ эх үүсвэр бий болгох чиглэлээр 55 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

1.9. Засгийн газрын гадаад зээл, тусламж

Монгол Улсын 2024 оны төсөвт нийт 1,783.0 тэрбум төгрөгийн гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг авч ашиглахаар төлөвлөгдсөнөөс 2024 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар Засгийн газрын гадаад төслийн зээл 1,154.5 тэрбум төгрөг буюу 94.0 хувийн гүйцэтгэлтэй, тусламж 169.4 тэрбум төгрөг буюу 30.0 хувийн гүйцэтгэл, нийт гүйцэтгэл 1,323.9 тэрбум төгрөг буюу 74.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Ангилал	Төслийн тоо	2024 оны батлагдсан төсөв	Гүйцэтгэл /2024.07.23/	Хувь	Үлдэгдэл
Гадаад зээл	101	1,225.0	1,154.5	94%	70.5
Гадаад тусламж	29	558.0	169.4	30%	388.6
НИЙТ	130	1,783.0	1,323.90	74%	459.1

Гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг нийт 19 хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагаас хүлээн авч, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хүснэгт 5. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (гэрбум төгрөг)

Д/д	Хөгжлийн түнш	Төслийн тоо	2024 оны батлагдсан төсөв	2024 оны санхүүжилтэд эзлэх хувь	Гүйцэтгэл /2024.07.23/
1	Азийн хөгжлийн банк	57	479.1	26.9%	383.5
2	АНУ	1	328.4	18.4%	128.6
3	БНХАУ	14	213.3	12.0%	135.0
4	БНСУ	7	235.8	13.2%	229.5
5	БНЭУ	2	126.6	7.1%	126.4
6	Дэлхийн банк	16	95.7	5.4%	68.9
7	ЕСБХБ	12	97.6	5.5%	83.1
8	Австри	4	68.6	3.8%	66.9
9	БНФУ	2	67.5	3.8%	59.7
10	ХБНГУ	3	24.1	1.4%	7.8
11	Япон	1	5.6	0.3%	3.7
12	ЕХОБ	2	12.1	0.7%	11.3
13	АДБХОБ	1	9.6	0.5%	9.6
14	Боловсролын Дэлхийн түншлэл	1	8.4	0.5%	1.9
15	БНПУ	2	6.8	0.4%	-
16	Люксембург	1	2.7	0.2%	0.5
17	Кувейт	2	1.0	0.1%	0.6
18	ХААХОУС	1	0.1	0.0%	0.01
19	Беларусь	1	0.01	0.0%	-
	НИЙТ	130	1,783.0		1,323.9

1.10.Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 30.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 38.6 хувьтай, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 30.2 их наяд төгрөгтэй тэнцэж өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 33.2 хувьтай тус тус тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 6. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2023	2024.II
I. Засгийн газрын дотоод өр		234.1	141.6
1.1	Үнэт цаас	234.1	141.6
II. Засгийн газрын гадаад өр		30,274.6	29,346.5
2.1	Үнэт цаас	9,141.9	8,716.3
2.2	Зээл	20,902.9	20,630.2
III. Засгийн газрын бусад өр		264.9	759.0
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	29.5	254.5
3.2	"Барих-шилжүүлэх" төрлийн концесс	230.9	0.0
3.3	Орон нутгийн зээллэг	4.5	504.5
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)		30,773.5	30,247.1
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (ӨҮЦ)		26,582.9	26,157.8
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		65.0%	60.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		38.6%	33.2%

Засгийн газрын зүгээс олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг сайтар судалсны үндсэн дээр 2024 оны төлөгдөх нөхцөлтэй “Хуралдай” бондын 600.0 сая ам.долларын төлбөрөөс 2023 онд хийсэн “Сенчири-2” болон “Сенчири-3” өрийн зохицуулалтуудын хүрээнд нийт 547.1 сая ам.долларыг шийдвэрлэсэн. Ингэснээр 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдөр үлдэгдэл 52.9 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс гүйцэтгэж “Хуралдай” бондын төлбөрийг бүрэн шийдвэрлэсэн болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Суурь тэнцлийн ашгийн ДНБ-д эзлэх хэмжээг 2.1 хувь буюу 1.6 их наяд төгрөгөөр Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлөхөөр тооцоолсон. Үүний дагуу төлөгдөх Засгийн газрын үндсэн төлбөрийн хэмжээ 1,545.9 тэрбум төгрөг /Хуралдай бондын дахин санхүүжүүлсэн дүнг оруулаагүйгээр/ байна. Ингэснээр суурь тэнцлийн ашгаар үндсэн төлбөрийг бүрэн төлж, үлдэгдэл хэмжээгээр өрийн зохицуулалт хийх буюу буцаан худалдан авалт хийх, ирэх онуудын үндсэн төлбөрийг төлөх боломж бүрдэнэ. Суурь тэнцлийн ашгаар Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулах нь Засгийн газрын өрийн дарамт, эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулах, цаашлаад хөрөнгө оруулагчид, олон улсын санхүүгийн байгууллагууд болон хөгжлийн түнш орнуудын Монгол Улсын төлбөрийн чадварт итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Олон улсын валютын сангийн тоон мэдээллээр төсвийн тусгай шаардлагуудын нэг болох өрийн хязгаарыг дэлхийн 72 улс оронд хүчин төгөлдөр мөрдөж байгаагаас 65 улс нь нэрлэсэн үлдэгдлээр Засгийн газрын өрийг тооцож, дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаанд хязгаар тогтоодог бол өнөөгийн үнэ цэнээр зөвхөн 7 улс тогтоож байна. Монгол Улсын хувьд 2011 оноос дундаж орлоготой улсад хамаарагдах болж, зөвхөн нэн хөнгөлөлттэй зээл бус олон улсын зах зээлд гадаад үнэт цаас, баталгаа гаргах, хоёр талт түншүүдээс арилжааны

зээл авах зэрэг олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах боломжтой болсон. Мөн дундаж орлоготой улс руу шилжсэнээс шалтгаалан ОУВС, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон бусад хөгжлийн түнш байгууллагуудаас авах гадаад зээлийн эх үүсвэр нь нэн хөнгөлөлттэй нөхцөлөөс аажим шилжиж хөнгөлөлттэй зээл, арилжааны зээлийн хосолсон нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийн төрлийг түлхүү санал болгож байна.

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2024 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 39.0 хувьтай, нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 44.7 хувьтай тус тус тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангахаар байна.

2.1. “Хурдтай хөгжлийн төлөөх зориг”-Шинэ 30 жилийн хөгжилд чиглэсэн төсвийн бодлого

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн дагуу сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор, эдийн засгийн өсөлтийг жил бүр 6-7 хувьд хадгалах, төрийн бүтээмжийг дээшлүүлж, цомхон чадварлаг, хүнд сурталгүй болгох, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулж, эдийн засгийг багадаа хоёр дахин тэлэх, эрчим хүчний либералчлалын хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх, орон сууцжуулалтын бодлогыг бүсчилсэн хөгжлийн төслүүдтэй уялдуулан зохион байгуулах, нийгэмд удаан хугацаанд хуримтлагдсан суурь асуудлуудыг шийдэх зэрэг олон чухал асуудлыг хамтран шийдвэрлэх талаар санал нэгдсэний үр дүнд Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн хамтарсан Засгийн газар байгуулагдаад байна.

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч буй сорилтыг цаг алдалгүй, хурдтай, үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор Хамтарсан Засгийн газарт нэгдсэн улс төрийн гурван намын мөрийн хөтөлбөр, нийтлэг зорилтод суурилсан “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” гэрээнд Монгол Улсын хөгжил дэвшлийг бодитойгоор урагшлуулж эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх томоохон зорилт тусгагдсан.

Энэхүү зорилтын хүрээнд хийгдэх томоохон бүтээн байгуулалт нь бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох “Шинэ сэргэлтийн таван тойрог” автозамын төсөл, Шинэ Хархорум төсөл, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг задалж төрийн байгууллагуудыг Хөшгийн хөндий рүү шилжүүлэх “20 минутын хот” төслийн хүрээнд хийгдэх Шинэ Зуунмод хот байгуулалтын төсөл, “Хөшгийн хөндийн туннелийн байгууламж”, “Өөдөө тэмүүлэх Монгол-Go Mongolia” ган татлагат гүүрэн байгууламж, “Шинэ тойрог зам”, “Туулын хурдны зам” болон “Төрийн байгууллагуудын нэгдсэн цогцолбор” төслүүд, эдийн засгийн бодлогын хүрээнд хийгдэх мега төслүүдийг тэтгэх эрчим хүчний реформ, түүнчлэн боомт, аялал жуулчлал, төмөр зам, дулааны болон усан цахилгаан станц, газрын тосны төслүүдийг хамтарсан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн, төсвийн тодотголд тусгалаа.

Дээр дурдсан бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжсэнээр Монгол Улсын хэмжээнд хөгжлийг хязгаарлаж байгаа хүчин зүйлс буюу эрчим хүч, авто зам, дулаан хангамж, орон сууц, түгжрэл, орчны бохирдол зэрэг дэд бүтцийн

тулгамдсан асуудлууд цогцоор шийдвэрлэгдэж, улмаар аймаг, орон нутгийн эдийн засгийн эргэлт сайжрах болно.

Монгол Улс уул уурхайн салбарын эрчимтэй өсөлтийн эхэн үе болох 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, 2013 оноос хэрэгжүүлж эхэлснээр төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн зарчмаар тооцох, тодорхой хэсгийг Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах, төсвийн зарлагын өсөлтийг уул уурхайн бус ДНБ-ний өсөлтөөр хязгаарлах, нэгдсэн төсвийн тэнцэл, Засгийн газрын өрийн хязгаарыг тогтоох зэрэг төсвийн тусгай шаардлагуудыг хэрэгжүүлж ирсэн.

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2013 онд 19.2 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5.9 их наяд төгрөг, гадаад худалдааны нийт эргэлт 6.1 тэрбум ам.доллар байсан бол 2023 оны эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 3.7 дахин өсөж 70.4 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3.9 дахин өсөж 23.3 их наяд төгрөг, гадаад худалдааны нийт эргэлт 2.3 дахин өсөж 24.4 тэрбум ам.долларт хүрч эдийн засгийн багтаамж 2-3 дахин тэлсэн байна. Мөн Ирээдүйн өв санд 3.4 их наяд төгрөг, Төсвийн тогтворжуулалтын санд 1.3 их наяд төгрөг хуримтлагдаад байна.

Хэдийгээр эдийн засаг төсөвт эерэг үр дүнгүүд гарч байгаа ч дотоод эх үүсвэр буюу татвар, шимтгэлийн орлогоор бүрдэх төсвийн орлогын өсөлт нь төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг өргөжүүлэх, төрийн албан хаагчдын цалин хөлс, ахмад настнуудын тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх зэрэг дотоодын бараа, ажил, үйлчилгээний төлбөрт голчлон зарцуулагдаж байна. Өөрөөр хэлбэл, уул уурхайн бус салбарын ДНБ-ий өсөлтийн хэмжээгээр хязгаарлагдсан нэгдсэн төсвийн зарлагын өсөлт нь дээр дурдсан төрийн дотоод үйл ажиллагаанд зарцуулагдахаас хэтрэхгүй байна.

Нөгөөтээгүүр, хүн амын өсөлт, шилжих хөдөлгөөний эрчим нь газар олголт, гэр хорооллын тэлэлт, тээврийн хэрэгслийн тооны өсөлтөөс улбаатай орчны бохирдол, авто замын түгжрэл, эрчим хүчний дутагдал, гамшгийн эрсдэл, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа зэрэг асуудлууд нь хүн амын эрүүл мэнд, амьдралын чанар, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгааг онцгой анхаарч, цаг алдалгүй шийдвэрлэх шаардлага үүсээд байна.

Хамтарсан Засгийн газарт орсон улс төрийн намуудын гэрээнд суурилсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжилд чиглэсэн томоохон төслүүд дээрх тулгамдсан асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх эхлэлийг тавьж байна.

Дээр дурдсан хөгжлийн асуудлуудыг дан ганц татварын орлогын эх үүсвэрээр шийдвэрлэх боломжгүй бөгөөд нэмэлтээр гадаад эх үүсвэртэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэх боломжтой байдаг. Гэвч нийт

зардлын өсөлтийг хязгаарласан төсвийн дүрэм буюу тусгай шаардлага нь төсөв хэт тэлэхээс сэргийлж байгаа боловч нөгөө талаас хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд гол байр суурь эзэлдэг гадаадын хөрөнгө оруулалт, гадаад эх үүсвэртэй санхүүжилтийг давхар хязгаарлаж иржээ.

Тиймээс хамтарсан Засгийн газрын бүтцийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөгжлийг урагшлуулах томоохон төслүүдийг бодитой хэрэгжүүлэх зорилгоор нэгдсэн төсвийн зарлага, төсвийн тэнцэл, Засгийн газрын өрийн тусгай шаардлагын бүтэц, агуулгыг шинэчилж олон улсын жишигт нийцүүлэх тогтолцооны суурь реформыг 2024 оны төсвийн тодотголын хүрээнд эхлүүлэх түүхэн цаг үе ирээд байна.

Монгол Улс өөрийн төсвийн дүрмээ ирэх 30 жилд хэрэгжүүлэх хөгжлийн төлөөх төсвийн бодлоготойгоо нийцүүлэх үүднээс нэгдсэн төсвийн суурь зарлагын бүтцэд зөвхөн дотоод эх үүсвэрээр санхүүжих зардлыг хамруулж гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, мөн үүнтэй зэрэгцээд төсвийн үндсэн тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 ба түүнээс дээш хувийн ашигтай байлгаж энэхүү ашгаар Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулан, улмаар төсөвт учруулах төлбөрийн ачааллыг бууруулах боломж бүрдэх юм.

2.2. Хөгжлийн бүтээн байгуулалтыг дэмжих “Төсвийн дүрэм”

Дэлхийн 106 улс төсөвтөө тодорхой дүрэм мөрдөж байна. Эдгээр улс орнууд хөгжлийн үе шат, онцлог, эдийн засгийн бүтцэдээ нийцүүлэн хөгжлийг хурдасгах томоохон төслүүд хэрэгжүүлэх, урсгал захиргааны зардлын өсөлтийг хязгаарлах, төсвийн төлөвийг бодитой үнэлэх зэрэг нийтлэг шалтгаанаар төсвийн дүрмээ шинэчилдэг туршлага байна. Тухайлбал, Япон Улс 1997 оноос төсвийн зарлага, алдагдлын хэмжээг хязгаарлаж эхэлснээс хойш 2001, 2023 онуудад эдийн засгийн өсөлтөө дэмжих, хүн ам зүйн асуудал, урт хугацаат өрийн асуудлаа шийдвэрлэх зорилгоор төсвийн дүрмээ шинэчилж байжээ. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Улс 1998 оноос “Алтан дүрэм”-ийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2010, 2014, 2019 онуудад төсвийн дүрэмдээ томоохон өөрчлөлтүүдийг хийж ирсэн нь хөгжлийг дэмжих дэд бүтцийн томоохон хөрөнгө оруулалт, төслүүдийг хэрэгжүүлэхэд уян хатан болгосны зэрэгцээ захиргааны урсгал зардалдаа илүү хяналт тавих боломжийг олгож байв. (Эх сурвалж: ОУВС)

Иймд Монгол Улсын дараагийн 30 жилийн хөгжлийн шинэ загварт тохирсон, дунд, урт хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг дараах байдлаар өөрчлөх нь зүйтэй байна. Үүнд:

- ✓ **Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг ДНБ-ий 30 хувиас хэтрүүлэхгүй байх:** байнгын шинжтэй, тогтмол гардаг төсвийн урсгал зардлыг эдийн засгийн багтаамжийн тодорхой хувиар хязгаарласнаар эдийн

засаг дахь төсвийн оролцоог хязгаарлах, хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зай үүсэх нөхцөл бүрдэх юм;

- ✓ **Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх:** Дотоод эдийн засгийн нөөц сууриас бүрдсэн тэнцвэржүүлсэн орлогын эх үүсвэрээр төсвийн зардлыг хязгаарлаж, суурь тэнцлийн ашгийг тооцох ба уг эх үүсвэрээр өрийн үндсэн төлбөрийг төлөхөд зарцуулна. Ингэснээр ирээдүйд өрийн дарамтад орох эрсдэлээс сэргийлнэ;
- ✓ **Засгийн газрын өрийг нэрлэсэн дүнгээр тооцох:** Дэлхий дахинд Засгийн газрын өрийн хязгаарыг мөрддөг 72 улс байгаагаас 65 улс нь нэрлэсэн үлдэгдлээр тооцож байна. Монгол Улс эдгээр орнуудын нийтлэг аргачлалд шилжсэнээр харьцуулах боломж нэмэгдэхийн зэрэгцээ олон нийтэд ойлгомжтой болж, хяналт тавихад хялбар болох юм.

Дээрх өөрчлөлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Өрийн удирдлагын тухай хуульд оруулснаар Монгол Улс шинэ 30 жилийн хөгжлийг эхлүүлэх томоохон төслүүдийг хэрэгжүүлж, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Шинэ сэргэлтийн бодлогод туссан зорилтуудад хүрнэ.

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв хооронд зохицуулалт хийх

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон мөн зарим яам агентлагийн нэр өөрчлөгдөөд байна.

Дээрх нөхцөл байдал нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийх үндэслэл, шаардлагыг бий болгож байна.

3.1. Хөгжлийн хөрөнгө оруулалт

3.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эхлүүлэх, бэлтгэл ажил, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн санхүүжилтийг төсөвт тусгаж, төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хотын хэт төвлөрөл, түгжрэлийг бууруулах, түүнчлэн Туул голыг дагаж Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ их тойруу дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглүүлж байна.

Монгол Улсын “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, мөн Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын зорилтуудыг хөрөнгө оруулалтын чиглэл болгож, энэ хүрээнд Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд үндэсний хэмжээний хөгжлийн томоохон бүтээн байгуулалтын дараах төслүүдийг шинээр тусгалаа:

№1: “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламж төсөл

Зураг 11. Ган татлагат гүүрэн байгууламж



/Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэлх/

Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх, түүнчлэн Туул голыг дагасан, Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ их тойруу дэд бүтцийг бүрдүүлэх мега төсөл болох “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд, уг гүүрэн байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн санхүүжилтэд шаардлагатай 28.6 тэрбум төгрөгийг Зам,

тээврийн сайдын багцад тусгалаа.

Гүүрэн байгууламж нь Улаанбаатар хотод баригдах бөгөөд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Богдхан уулын Хүрхрэн ам хүртэлх ган татлагатай 6 эгнээ бүхий 4.7 км авто зам, 900 метр урт гүүр, 80 метр урт нүхэн гарц бүхий бүтэцтэйгээр төлөвлөж байна.

Гүүрэн байгууламжийг бүтээн байгуулалтын хүрээнд Туул голын эргийг иргэдийн амралт, аяллын зориулалтаар тохижуулах ажил нь төслийн бүрэлдэхүүнд багтах юм.

Зураг 12. Гүүрэн байгууламж



№2: “Хөшигийн хөндийн туннел” төсөл /Улаанбаатар хот болон хөшигийн хөндий/

Зураг 13. Хөшигийн хөндийн туннел



Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх, Туул голыг дагасан, Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ их тойруу дэд бүтцийг

бүрдүүлэх мега төсөл болох “Хөшигийн хөндийн туннел” төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд уг гүүрэн байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн санхүүжилтэд шаардлагатай 55.3 тэрбум төгрөгийг Зам тээврийн сайдын багцад тусгалаа.

Хөшигийн хөндийн туннел нь 15.2 км урт бүхий 2 эгнээтэй хос туннел бөгөөд Богдхан уулын Их тэнгэрийн амнаас Богдхан уулсын Номтын ам руу барихаар төлөвлөсөн.


Хөшигийн хөндийн туннел нь Улаанбаатар хотод хэрэгжих эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий үндэсний томоохон төсөл бөгөөд төслийн хувьд зам тээвэр, аялал жуулчлалын салбарын хөгжилд эерэг үр нөлөө үзүүлэхүйц, нөгөө талдаа бүтээн байгуулалтын хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх, олон улсын туршлагыг нутагшуулах, үндэсний аж ахуй нэгжүүдийг бизнесийн чадавхыг нэмэгдүүлэх зэрэг олон талын үр ашигтайгаас гадна үндэсний бэлгэ тэмдэг бүхий түүхэн бүтээн байгуулалт болно гэж үзэж байна.

Зураг 14. Хөшигийн хөндийн туннел




№3: “Шинэ тойрог авто зам” төсөл /Улаанбаатар хот, их тойруу/

Зураг 15. Шинэ тойрог авто зам



Нийслэл Улаанбаатар хотын Их тойруугийн гудамжийг дахин инженерчлэх, хотын түгжрэлийг бууруулах, авто замын сүлжээг өргөтгөх арга хэмжээний хүрээнд “Шинэ тойрог авто зам” төслийг төлөвлөж, төслийн хүрээнд 13.4 км урт бүхий тойрог авто замуудыг барьж байгуулах ажлын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвт шаардлагатай 16.9 тэрбум төгрөгийг Зам тээврийн сайдын багцад тусгалаа.

Зураг 16. Шинэ тойрог авто зам



төлөвлөсөн.

Төслийг 2024-2028 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2024 онд урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдсэний үндсэн дээр нийслэлийн 2025 оны төсөвт барилга угсралтын ажлын санхүүжилтийг тусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр

№4: “Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор” төсөл /Номтын ам, Шинэ зуунмод хот/

Улсын Их Хурлын 2024 оны “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” 12 дугаар тогтоол, 2024 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 40 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборыг барьж байгуулахаар болсон.

Түүнчлэн Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор хүргэх шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах, Туул голыг дагасан, Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ их тойруу дэд бүтцийг бүрдүүлэх бодлогын хүрээнд Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний

Зураг 17. Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор



цогцолборыг Хөшигийн хөндийн Номтын аманд байгуулахаар төлөвлөж, барилгын хэмжээ урьдчилсан байдлаар 70,000 м² бөгөөд төслийн төсөвт өртгийг 676.3 тэрбум төгрөг, 2024 онд санхүүжих дүн болох 100.0 тэрбум төгрөгийг 2024 оны төсвийн тодотголд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад тусгалаа.

Ингэснээр цогцолборыг эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга байхаар төлөвлөн, 2024 онд төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулан барилга угсралтыг эхлүүлж, 2027 онд ашиглалтад оруулахаар төлөвлөв.

№5: “Туул хурдны авто зам” төсөл. /Улаанбаатар хотын баруун хэсгээс зүүн хэсэг хүртэлх/

Зураг 18. Туул хурдны авто зам



Улаанбаатар хотын түгжрэлийг дорвитой бууруулах томоохон бүтээн байгуулалт буюу Туул голыг дагасан, Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ их тойруу дэд бүтцийг бүрдүүлэх бодлогын хүрээнд хэрэгжих хөгжлийн төслийн нэг нь “Туулын хурдны авто зам” төсөл бөгөөд 6 эгнээ

бүхий 33 км урт хурдны замыг Улаанбаатар хотын баруун хэсгийг зүүн хэсэгтэй холбосон Туул голыг дагасан хурдны авто зам байгуулагдана.


Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2014 онд олон улсын байгууллагын санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн байдаг бөгөөд үүнд үндэслэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу нийслэлийн ТХХТ байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Уг төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бөгөөд барилга угсралтыг 2025 онд эхлүүлэх, түншлэлийг гэрээг олон улсын “ЕРС” гэрээний нөхцөлөөр төлөвлөж, ингэснээр төслийг богино хугацаанд хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Зураг 19. Туул хурдны авто зам



Үүнтэй уялдуулан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

№6. Улаанбаатар хотын “Шинэ Их Тойруу” хурдны зам төсөл /25 км радиустай тойргоор явах тойрог хурдны зам/



Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх, Туул голыг дагасан, Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ их тойруу дэд бүтцийг бүрдүүлэх мега төсөл болох “Шинэ Их Тойруу хурдны авто зам” төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд уг төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн санхүүжилтэд шаардлагатай 23.0 тэрбум төгрөгийг Зам тээврийн сайдын багцад тусгалаа.

Мөн хөгжлийн бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээний санхүүжилт болох 50.0 тэрбум төгрөгийг Монгол Улсын сайд бөгөөд 20 минутын хот Үндэсний хорооны даргын багцад тусгав.

Бүсчилсэн бүтээн байгуулалтын төслүүдийн бэлтгэл ажлыг хангана. Бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөвт шаардлагатай 70.0 тэрбум төгрөгийг төсвийн тодотголд тусгав.

Зураг 20. Бүсийн хөгжил



Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж бүсийн хөгжлийг дэмжих, Шинэ сэргэлтийн бодлогод туссан бүтээн байгуулалтын төслүүдийг ирэх онуудын төсөвт тусгах, мөн бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах

арга хэмжээний хүрээнд 60.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монгол Улсын Шадар сайдын багцад, харин Улаанбаатар хотын бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн зардалд 10.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын багцад тус тус тусгалаа.

“Шинэ Хархорум” хот төслийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

Зураг 21. Шинэ Хархорум хот



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих бодлогын хүрээнд “Шинэ Хархорум” хотыг байгуулах судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад санхүүжилтэд 30.0 тэрбум төгрөгийн

төсөвт өртөгтэй, 15.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд уг ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2024 оны төсвийн тодотголоор санхүүжих дүнг 15.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 30.0 тэрбум төгрөг болгов.

“Шинэ Хархорум” хотыг байгуулснаар Бүс, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, Улаанбаатар хотод үүссэн хүн ам, эдийн засгийн хэт төвлөрлийг сааруулан, түүхэн өв уламжлалаа сэргээж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бататгана.

“Шинэ Хархорум” хотын газар нутгийн 50% нь ногоон байгууламж байх, гадаргын ус, саарал усыг дахин ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг ашиглах, байгаль орчинтой харилцан уялдаатай, амьтны амьдрах орчинд ээлтэй, хүн амьдрахад таатай, явган алхалт, унадаг дугуй, нийтийн тээврийн хэрэглээг дэмжсэн, эдийн засгийн хувьд бие даан хөгжсөн хот байх зарчмыг баримтлан урьдчилсан байдлаар 500,000 хүн амтай байхаар тооцож төлөвлөж байна.

Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төслийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын газар нутгийг бүрэн хамарсан, орон зайн ялгаваргүй байдлаар харилцаа холбооны тоон системийн сүлжээ үүсгэх зорилготой уг төслийг хэрэгжүүлснээр интернэт суурьтай бүх төрлийн харилцаа холбооны үйлчилгээг байршлаас үл шалтгаалан иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх боломжийг нээж өгнө. Мөн шилэн кабелийн сүлжээнээс

хамааралгүй интернэтийн гуравдагч гарцтай болох, онцгой байдлын үед байнгын харилцаа холбоотой байх, гамшиг ослын эрсдэлийг бууруулах, хот хөдөөгийн иргэдийн тоон ялгааг арилгах, хөдөөгийн иргэд, малчдын хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зайн сургалтад хамрагдах чухал ач холбогдолтой.

Тус төслийг БНФУ-ын нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд санхүүжилтийн 15 хувь буюу нийт 68.8 тэрбум төгрөгийг Монголын талын хөрөнгө оруулалтад тусгалаа.

3.1.2. Гадаад зээл тусламжаар хэрэгжих хөгжлийн бүтээн байгуулалтууд:

Гадаад зээлийн төслүүдийн гүйцэтгэл, олон улсын гэрээнд үндэслэн зарим төслүүдийн зээлийн ашиглалтыг нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгав.

Дэлхий нийтийг хамарсан халдварт цар тахал, геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор хэрэгжилт нь удааширсан гадаад зээл, тусламжийн төслүүд 2023 оноос идэвхжиж, мөн гадаад байсан олон төслийн хэрэгжилтийг сүүлийн жилүүдэд Засгийн газраас эрчимжүүлсэнтэй холбоотойгоор 2023-2024 онуудад зээл, тусламжийн төслүүдийн гүйцэтгэл сайжирсан тул 2024 онд батлагдсан зээлийн ашиглалтыг нэмэгдүүлж, үндэсний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажлыг гэрээнд заасан хугацаанд ашиглалтад оруулах зорилгоор 2024 оны төсвийн тодотголд 984.0 тэрбум төгрөгийг тусгалаа.

Гадаад зээлийн 2024 оны ашиглалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын санал, олон улсын гэрээний үүрэг болон төслүүдийн гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлсэн бөгөөд эдгээр 11 төслийн 9 төсөл нь дэд бүтцийн томоохон төслүүд байна. Үүнд:

№1: “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” барих төсөл /2023-2027/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эрчим хүчний яам

Хөгжлийн түнш: БНХАУ-ын ЭКСИМ банкны зээл

Нийт санхүүжилтийн дүн: 266.5 сая ам.доллар

Зураг 22. Хиймэл дагуулын төслийн загвар зураг



Баруун бүсийн болон эрчим хүчний нэгдсэн системийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг найдвартай эх үүсвэрээр хангах, эрчим хүчний системийн аюулгүй байдлыг нэмэгдүүлж, импортын эрчим хүчний хэмжээг бууруулах, нөхөн сэргээгдэх эх үүсвэрийн

нөөцийг бий болгож, бүс нутгийн эдийн засгийн чадавхыг сайжруулах зорилгоор Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай УЦС-ыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр байгуулахаар зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан. Төсөл амжилттай хэрэгжсэнээр жилд ойролцоогоор 756.6 мян.тонн нүүрс шатаасантай тэнцэх нүүрсхүчлийн хий ялгаралтыг бууруулна, баруун аймгуудын импортын цахилгааны хараат байдлаас гарч, 100% дотоодын эх үүсвэрээр хангагдана, УЦС-ын усан сангийн дагуу аялал жуулчлалын бүс бий болно.

Зураг 23. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц



Төслийн гүйцэтгэгчтэй 2021.09.17-ны өдөр байгуулсан гэрээний дагуу урьдчилгаа 30 хувийг тусгайлсан зээлийн гэрээ зурагдсанаар санхүүжүүлэхээр тусгагдсан тул 2024 оны төсвийн тодотголд 256.8 тэрбум төгрөгийг тусгалаа.

№2: Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл /2017-2027 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Хөгжлийн түнш: БНЭУ-ын ЭКСИМ банкны зээл

Санхүүжилтийн нийт дүн: 1,236.0 сая ам.доллар

Нийт ажлын гүйцэтгэл: 17%

Нийт зээлийн ашиглалт: 21%

Зураг 24 Газрын тос боловсруулах үйлдвэр



Жилд 1.5 сая тонн түүхий тос боловсруулж, дотоодын хэрэглээний 80%-ийг хангах үндэсний үйлдвэр бий болох ба шинээр 700+ ажлын байр бий болно. Тус үйлдвэр ашиглалтад орсноор Евро - 4,5 стандартын шаардлага хангасан 339.0 мянган тонн автобензин, 824.0 мянган тонн дизель түлш, онгоцны түлш 80.0 мянган тонн, 43.0 мянган

тонн шингэрүүлсэн шатдаг хий болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ. Мөн импортын хараат байдлаас гарч, шатахууны үнийг бие даан зохицуулах боломж бүрдэнэ.

Тус төслийн ажлын 2024 онд санхүүжих гүйцэтгэлтэй уялдуулан 52.7 тэрбум төгрөгийг 2024 оны төсвийн тодотголд тусгалаа.

№3: Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл /2020-2025 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Хөгжлийн түнш: БНХАУ-ын ЭКСИМ банкны зээл

Нийт санхүүжилтийн дүн: 262.7 сая ам.доллар

Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 85%

Нийт зээлийн ашиглалт: 72%

Улаанбаатар хотод шинээр хоногт 250,000 м³ ахуйн болон үйлдвэрийн

Зураг 25. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын зураг



хаягдал ус цэвэрлэх байгууламж барьж, цэвэрлэгдсэн усны чанарыг Монгол Улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэнэ.

Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн хүрээнд нийт 55 барилга байгууламж

баригдаж байгаа бөгөөд бохир ус цэвэрлэх, лаг боловсруулах гэсэн үндсэн хоёр технологийн дагуу ажиллахаар төлөвлөсөн. Цэвэрлэх байгууламжид усны төв коллектороор дамжуулан бохир усыг өөрийн урсгалаар хүлээн авч бохир усанд механик цэвэрлэгээ, биологи цэвэрлэгээ, нэмэлтээр физик, химийн цэвэрлэгээ хийгдэнэ.

Төслийн хүрээнд нийт 32.45 сая ам.долларын санхүүжилтийн хүсэлт ирсэнтэй холбогдуулан 2024 оны төсвийн тодотголд 110.0 тэрбум төгрөгийг тусгалаа.

№4: Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл /2020-2027 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Хөгжлийн түнш: БНСУ-ын ЭКСИМ банкны зээл

Нийт санхүүжилтийн дүн: 266.9 сая ам.доллар

Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 13%

Нийт зээлийн ашиглалт: 30%

Зураг 26. Солонго 1 хороолол

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын агаар хөрсний бохирдлыг бууруулах, зорилтот бүлгийн иргэдийг орлогод нийцсэн орон сууцаар хангах хүрээнд 17.5 га газарт 5002 айлын 66 блок 18,000 хүн амьдрах 2,706 авто зогсоолтой орон сууцны цогцолбор хороолол барина.



Барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгч нь орон сууцны барилга угсралтын ажлыг энэ онд 35%-д хүргэхээр ажиллаж байгаа бөгөөд төслийн ажлын гүйцэтгэлд олгох нийт 150.1 тэрбум төгрөгийг 2024 оны төсвийн тодотголд тусгалаа.

№5: Улаанбаатар-Дарханы чиглэлд нэмэлт 2 эгнээ зам барих төсөл /2020-2024 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Зам, тээврийн яам

Хөгжлийн түнш: ЕСБХБ-ны зээл

Нийт санхүүжилтийн дүн: 157.0 сая ам.доллар

Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 94%

Нийт зээлийн ашиглалт: 54%

Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км 4 эгнээ авто замыг шинээр барьснаар бүс нутгийн зам тээврийн аюулгүй байдал, дэд бүтэц, нэвтрэх хүчин чадал нэмэгдэж иргэдийн амьдралын чанар сайжрахаас гадна олон улсын болон орон нутгийн дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлж, дотоодын худалдаа, зах зээлийг хөгжүүлэн олон улс, бүсийн ач холбогдол бүхий нийгэм, эдийн засгийн үр ашигтай.

Зураг 27. Улаанбаатар-Дархан чиглэлийн 4 эгнээ зам



Тус төсөл нь 2024 онд бүрэн хэрэгжиж дуусах тул замын ажлын 131.5 тэрбум төгрөгийг 2024 оны төсвийн тодотголд тусгалаа.

№6: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр /2014-2027 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн засаг даргын тамгын газар

Хөгжлийн түнш: АХБ, ЕХОБ-ны зээл, тусламж

Нийт санхүүжилтийн дүн: 224.0 сая ам.доллар үүнээс 220.3 сая ам.доллар зээл, 3.7 сая ам.доллар тусламж /Нийслэлийн хөрөнгө оруулалт 120.20 сая ам.доллар/

Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 60%

Нийт зээлийн ашиглалт: 67%

Гэр хорооллын бүсэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг цогц, иж бүрэн барьж байгуулснаар **Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх суурь** нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд нийт 6 дэд төв (Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Толгойт, Дэнжийн мянга, Шархад)-д нийт 32 км авто зам, 3 гүүр (24м, 30м, 60м), 67 км дулааны шугам, 17.8 км үерийн хамгаалалтын суваг, 7.6 км хөрсний ус зайлуулах шугам зэрэг инженерийн дэд бүтэц бий болно. Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн ажил 100 хувь хийгдсэн байна.

Зураг 28. Хөтөлбөрийн байршлын зураг



Төслийг хугацаанд нь амжилттай хэрэгжүүлж төслийг эрчимжүүлэхэд шаардлагатай 61.1 тэрбум төгрөгийг 2024 оны төсвийн тодотголд тусгалаа.

№7: Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл /2019-2027 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн засаг даргын тамгын газар

Хөгжлийн түнш: АХБ-ны зээл

Нийт санхүүжилтийн дүн: 228.0 сая ам.доллар

Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 40%

Нийт зээлийн ашиглалт: 10%

Нийт тусламжийн ашиглалт: 5%

Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөн, эко хороолол бүхий орлогод нийцсэн ногоон орон сууц, нийгмийн дэд бүтцийг цогцоор нь шийдвэрлэж, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулахад оршино. Гэр хорооллын 30.8 га талбайд 4,988 өрхийн орлогод нийцсэн ногоон орон сууц бүхий эко хороолол барихаар төлөвлөөд байна.

Зураг 29. Орлогод нийцсэн ногоон орон сууцны хороолол



Төслийн хүрээнд хийгдэх газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэхэд 71.6 тэрбум төгрөг шаардлагатай байгаа тул 2024 оны төсвийн тодотголд тусгалаа.

№8: 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл /2018-2024 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эрчим хүчний яам
Хөгжлийн түнш: БНСУ-ын ЭКСИМ банкны зээл
Нийт санхүүжилтийн дүн: 148.7 сая ам.доллар
Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 45%
Нийт зээлийн ашиглалт: 40%

Зураг 36. Говьсүмбэр аймгийн төвийн дулааны станцын барилга, угсралтын ажил



Төвлөрсөн дулаан хангамжийн системгүй 10 аймгийн (Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Төв, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар) төвд дэвшилтэт технологийн дулааны станц, дулааны шугам сүлжээ барьснаар иргэдийг найдвартай халаалт, хэрэгцээний халуун усаар жилийн турш хангах,

дулаан үйлдвэрлэлээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаас гадна нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулах, бүс нутгийг хөгжүүлнэ. Төслийн хүрээнд 10 дулааны станц, 88 дулаан дамжуулах төв, 67 км дулааны шугам, 1,400 шинэ ажлын байр бий болох ба 958 ААН, 606 төсөвт байгууллага, 691 нийтийн орон сууц, 1,433 амины орон сууцны дулаан хангамж шийдэгдэнэ.

Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд 2024 онд нийт 11.4 сая ам.доллар буюу 38.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж шийдвэрлэх шаардлагатай тул төсвийн тодотголд тусгалаа.

№9: Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл /2020-2025 он/

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эрчим хүчний яам
Хөгжлийн түнш: ДБ-ны зээл
Нийт санхүүжилтийн дүн: 41.0 сая ам.доллар
Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 67%
Нийт зээлийн ашиглалт: 23%

Эрчим хүчний салбарт баримтлах дунд хугацааны хөтөлбөрийн биелэлтийг хангах, Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу бий болох орон сууцны хороолол, нийгэм ахуйн барилга байгууламжуудын хэрэглээг эх үүсвэрүүдийн хүчин чадлын өргөтгөлтэй уялдуулан дулааны эрчим хүчээр хангах, техникийн боломжийг бүрдүүлэх, төвлөрсөн дулаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах, сонгосон төслийн талбайд дулааны сүлжээний хүчин чадлыг тэлж, үр ашигтай байдлыг нь сайжруулахад оршино.

Төслийн үр дүнд дулааны шугам сүлжээний найдвартай ажиллагаа сайжрах, ашиглалтын хугацаа нэмэгдэх, дулааны эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах, агаарын бохирдлыг бууруулах зэрэг байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх бөгөөд ашиглалтын хугацаа дууссан шугамуудыг өргөтгөн шинэчилснээр ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах 20,000 айлын орон сууц, 30,000 хүүхдийн сургууль, 7,000 хүүхдийн цэцэрлэг, 10,000 ажлын байрыг дулааны эрчим хүчээр хангах техникийн боломжийг бүрдүүлэх юм.

Зураг 31. Дулаан хангамжийн шугам сүлжээний шинэчлэлийн ажил



Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж шинэчлэл хийгдэж байгаа дулааны шугамуудыг халаалтын улирлаас өмнө бүрэн ашиглалтад оруулахын тулд 2024 оны төсвийн тодотголд 38.8 тэрбум төгрөгийг тусгалаа.

Дээрх 9 томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслөөс гадна Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 2 төслийн нийт 72.5 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр тусгасан болно.

Гадаад зээлийн энэ онд батлагдсан санхүүжилтийг төсвийн тодотголын дагуу нэмэгдүүлснээр нийт 2,209.0 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалт 2024 онд бүрэн санхүүжих хүлээлттэй байна.

3.2. Төсвийн урсгал зардал

Нэгдсэн төсвийн урсгал зардлыг ДНБ-ний 30 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримталж, зарлагын өсөлтийг хүн ам зүйн статистик өөрчлөлтөөр нэмэгдэх нийгмийн суурь үйлчилгээ болон инфляц, ханшийн өөрчлөлттэй уялдаж нэмэгдэх бараа, ажил, үйлчилгээний зардал, шинээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад голлон чиглүүлнэ.

Түүнчлэн төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах, төрийн байгууллагуудын орон тооны давхардлыг арилгах, төрийн үйл ажиллагааг хүрэх үр дүн, гүйцэтгэлд суурилж санхүүжүүлэх бодлого баримтлах бөгөөд үүнтэй холбогдуулан бүтээмжийг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэл, цалин хөлсний тогтолцоо, бараа, үйлчилгээний тариф, нормативыг шинэчлэх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.2.1. Улсын төсвийн урсгал зарлага

2024 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн урсгал зарлага ДНБ-ний 28.7 хувийг эзэлж байгаа бол харин нэгдсэн төсвийн нийт зарлагын 37.0 хувийг эзэлж байна. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын бүтцийг авч үзвэл 32.6 хувийг нь төрийн албаны цалин хөлсний зардал, 24.4 хувийг нь тэтгэвэр тэтгэмжийн зардал тус тус эзэлж байгаа бөгөөд тус хоёр зардал нь нийлээд урсгал зарлагын 57.0 хувийг буюу талаас илүүт нь эзэлж байна. Салбараар нь авч үзвэл боловсролын зарлага 16.1 хувийг, эрүүл мэндийн зарлага 8.1 хувийг, нийгмийн хамгааллын зарлага 28.8 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд нийгмийн суурь үйлчилгээний тус 3 салбарын урсгал зарлага нийлээд нэгдсэн төсвийн урсгал зарлагын 63.7 хувийг, ДНБ-ний 18.3 хувийг тус тус эзэлж байна.

Цомхон, бүтээмжтэй төрийн байгууллагын тогтолцоотой байх, үргүй зардлыг бууруулах зорилгоор урсгал зарлагыг ДНБ-ны 30.0 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримталж байгаа бөгөөд энэхүү хязгаарлалт нь эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшилд үйл ажиллагаа явуулах орон зайг бий болгох давхар ач холбогдолтой.

Цомхон, бүтээмжтэй төртэй байхын тулд эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд үзүүлдгээс бусад төрийн албан хаагчдын тоог жил бүр 10 хүртэл хувиар бууруулах, төрийн албаны анхан болон дунд шатны нэгж дэх давхардлыг арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Эрчим хүчний салбарт реформ хийх нөхцөл бүрдүүлнэ

Монгол Улсад цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлттэй уялдан жил бүр 6-7 хувиар нэмэгдэж байгаа боловч шинэ эх үүсвэр нэмэгдэхгүй байгаагаар холбогдуулан дотоодын дулааны цахилгаан станц(ДЦС)-уудын хүчин чадал дутагдаж, импортын эрчим хүчний хараат байдал улам нэмэгдэж байна.

Эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадлын 81,5%-ийг ДЦС эзэлж байгаа ба цахилгаан эрчим хүчний хэрэглээний хоногийн графикаар их бага ачааллын зөрүү 280-350 МВт-д хүрч байна. Ачааллын зөрүүний дийлэнх хувийг импорт, экспортын эрчим хүчээр зохицуулж байгаа боловч 2022-2023 онд 116 МВт, 2023-2024 оны 83 МВт-ын чадлын дутагдалд систем орж тодорхой хэмжээнд хэрэглэгчийн хэрэглээг хязгаарлаж байна. Эрчим хүчний үнэ тарифыг үйлдвэрлэл, дамжуулалт, түгээх үйлчилгээний бодит өртгөөс бага тогтоогдож ирсэн нь салбарын санхүү, эдийн засгийн нөхцөлийг жил бүр сулруулах суурь шалтгаан болж байна.

Тиймээс цаашид эрчим хүчний салбарын үнэ тарифыг бодит өртгөө нөхдөг байх зарчимд шилжүүлж хувийн хэвшлийн аж ахуйн нэгж тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд олон жил хуримтлагдсан суурь үнэ тарифыг өөрчилж, цаашид алдагдал болон өр төлбөр хуримтлуулдаг бус

өрсөлдөөнийг бий болгож, салбарт хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэл хийх боломжийг бий болгох үүднээс тус салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх зорилгоор эрчим хүчний салбарт шинэчлэл хийх шилжилтийн үеийн зардлыг санхүүжүүлэхэд зориулж 131.1 тэрбум төгрөг хуваарилахаар тооцов.

Шилжилтийн хугацаанд хэрэгжүүлэх цогц арга хэмжээний үр дүнд бүсүүд дэх эрчим хүчний бие даасан аж ахуйн нэгжүүлийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж нэгдсэн сүлжээний хүрээнд алдагдалгүй ажиллаж эхлэх бөгөөд 2025 оноос эхлэн улсын төсвөөс эрчим хүчний алдагдлын татаас олгохгүй байхаар тооцож байна.

Гучин жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын реформыг цаг алдалгүй эхлүүлснээр эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аж үйлдвэржилт, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх мега төслүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Цаашлаад сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, устөрөгч, метан хий, цөмийн эрчим хүч зэрэг шинэ технологи ашиглах чиглэлээр бодлогын дэмжлэг үзүүлж эрчим хүч экспортлогч улс болох томоохон зорилт тавьж байна

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв хооронд зохицуулалт хийнэ

Монгол Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох хууль, тогтоомжийн төслийг хэлэлцэн баталсан.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдаж, зарим яамдын эрхлэх асуудал, чиг үүрэгт өөрчлөлт орсон тул шинэ бүтцийг дагалдуулан чиг үүрэг хэрэгжүүлэх төсвийг шилжүүлэх өөрчлөлтийг тусгалаа. Үүнд: Залуучуудын хөгжлийг дэмжих бодлого, аялал жуулчлалын бодлого, биеийн тамир, спортын хөгжлийн бодлогын асуудлыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын чиг үүрэгт, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудлыг Эдийн засаг, хөгжлийн сайдын чиг үүрэгт, чөлөөт бүсийн хөгжлийн асуудлыг Монгол Улсын Шадар сайдын чиг үүрэгт тус тус шилжүүлсэн.

Мөн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга төсвийн ерөнхийлөн захирагчийг шинээр байгуулж, Монгол Улсын Шадар сайдын чиг үүрэгт төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хөрөнгө оруулалт, гадаад худалдаа, шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудлыг, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын чиг үүрэгт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны

хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах асуудлыг тус тус нэмж тусгалаа.

3.2.2. Нийслэл Улаанбаатар хотын төсвийн суурь зарлага

Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар 500.0 сая ам.долларын нийслэлийн гадаад үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалах шийдвэр гарсан.

Нийслэл хотын нутаг дэвсгэр жилээс жилд тэлсээр байгаа боловч гэр хороолол нь төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдоогүй, нийгэм, соёлын үйлчилгээнээс алслагдсан зэрэг нийтлэг шинж чанар нь хотын байгаль экологи, хүн амын хөгжилд олон талын сөрөг нөлөөг үзүүлж байна. Иймээс “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, нийслэлийн дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн 3 үе шаттайгаар Сэлбэ дэд төв орчмын 158 га газрыг оновчтой зохион байгуулан хөгжүүлж, 12,000 айлын орон сууц, 960 хүүхдийн 3 сургууль, 240 хүүхдийн 5 цэцэрлэг, спорт цогцолбор, соёл олон нийтийн төв, эмнэлэг, хорооны цогцолбор барилга байгууламж, салбар шугам, авто зам, явган зам, ногоон байгууламж, тохижилтын бүтээн байгуулалтыг хийхээр төлөвлөн шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал, түүнчлэн төслийн талбайд хамрагдаж байгаа 2,206 нэгж талбарыг чөлөөлөхөд шаардлагатай нөхөн олговрын зардлыг нийслэлийн төсвийн суурь зарлагад тус тус нэмж тусгалаа.

3.3. Болзошгүй өр төлбөр

Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас өрийн удирдлагын оновчтой шийдвэр гаргаж, зээлийн эргэн төлөлтийг эрчимтэй хийлгэснээр хугацаа тулаад байсан Засгийн газрын өрийн баталгаат “Самурай” бондын 30 тэрбум иений төлбөрийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны өөрийн хөрөнгөөр төлж барагдуулсан болно.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 133 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Хөгжлийн банкны 420 сая юанийн зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд зориулж Монгол Улсын Хөгжлийн банканд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд тус дулааны цахилгаан станцын өргөтгөл нь 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ашиглалтад орсон. Уг зээлийн эргэн төлөлт 2031 онд төлөгдөж дуусах хуваарьтай байна.

Ийнхүү 2023 онд Засгийн газрын өрийн баталгаат үнэт цаасыг төлж барагдуулснаар болзошгүй өр төлбөрийн хүрээнд 2031 он хүртэл томоохон эрсдэлгүй болоод байна.

Цаашлаад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 201 дугаар тогтоол болон 06 дугаар сарын 06-ны өдрийн 264 дүгээр тогтоолын дагуу 2024 онд дотоодын зах зээлд 1.0 их наяд төгрөгийн үнэт цаасыг арилжаалж “Бөөрөлжүүтийн ДЦС”, “Батарей хуримтлуурын станц”, “Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил”, “Ариутгах Бохир усны Туул-1 коллектор болон үерийн байгууламж” зэрэг төслүүдийг санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна. Үүнээс эхний ээлжид 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр 500 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан болно.

Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.1} дэх хэсэгт нийслэлийн гадаад үнэт цаасыг Засгийн газрын өрийн баталгаатай гаргаж болохоор заасан бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоол болон Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 265 дугаар тогтоолоор нийслэлийн 500 сая ам.долларын гадаад үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгосон болно.

4.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 28,872.5 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 27,269.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,603.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байхаар тооцлоо. Тус суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 БАТ	2024 ТОД	ЗӨРҮҮ
НИЙТ ОРЛОГО	27,722.2	30,639.5	2,917.4
Тогтворжуулалтын сан	513.7	478.6	-35.2
Үндэсний баялгийн сан	1,353.3	1,288.5	-64.8
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	25,855.1	28,872.5	3,017.3
НИЙТ ЗАРЛАГА	27,360.5	30,487.9	3,127.4
Урсгал зардал	21,221.9	22,431.5	1,194.5
Хөрөнгийн зардал	6,273.3	8,071.0	1,797.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-134.7	-14.6	120.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-1,505.4	-1,615.4	-110.0
ДНБ-д эзлэх хувь	-2.0%	-2.0%	-
СУУРЬ ЗАРЛАГА	-	27,269.0	-
ДНБ-д эзлэх хувь	-	34.4%	-
СУУРЬ ТЭНЦЭЛ	-	1,603.5	-
ДНБ-д эзлэх хувь	-	2.0%	-

4.2. Төсвийн тусгай шаардлага

☐ **Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2024 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 182.5 ам.доллар байхаар тооцлоо.

☐ **Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтийн дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

	2024
Хуулийн хязгаар	2.0%
Төсөөлөл	2.0%

□ **Тухайн жилийн нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ** тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтийн дагуу тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь

ӨСӨЛТ	2024
Хуулийн хязгаар	30.0%
Төсөөлөл	28.3%

□ **Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д оруулж байгаа өөрчлөлтийн дагуу “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2023-2025 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 10. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)

	2024
Хуулийн хязгаар	60.0%
Төсөөлөл	43.5%

4.3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тайлбар

1 дүгээр зүйл.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйл - Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсанаар Ирээдүйн өв санд 2024 онд орлого төвлөрүүлэх, хуримтлуулахтай холбогдсон харилцааг тусдаа хуулиар буюу Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хуулиар зохицуулах болсон тул Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйл буюу хуулийн зорилт хэсгээс Ирээдүйн өв сантай холбоотой хэсгийг хасахаар тусгав.

2/3 дугаар зүйл - Төсвийн тодотгол хийх үндэслэл бүлэгт дурдсаны дагуу Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын шинэчилсэн дүнг хүснэгтээр тусгасан.

3/5 дугаар зүйл - Төсвийн тодотгол хийх үндэслэл бүлэгт дурдсаны дагуу Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарын эргэн төлөх үндсэн төлбөрийн хэмжээний шинэчилсэн дүнг хүснэгтээр тусгасан.

4/6 дугаар зүйл - Төсвийн тодотгол хийх үндэслэл бүлэгт дурдсаны дагуу Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарцуулах зардал, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох зарцуулалтын хэмжээг шинэчилсэн дүнг хүснэгтүүдээр тусгасан.

5/16-18 дугаар зүйл:

16 дугаар зүйл - Монгол Улсын 2024 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.

17 дугаар зүйл - Монгол Улсын 2024 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.

18 дугаар зүйл – Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн төсөөлөл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Монгол Улсын 2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.

2 дугаар зүйл.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан " *"Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт"* -ыг 1 дүгээр хавсралтаар өөрчилсөн.

3 дугаар зүйл.

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:

“6.5.Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д заасан аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалтад сонирхогч этгээд, оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгчээр оролцох, эсхүл бараа, үйлчилгээний нийлүүлэгч, үйлдвэрлэгч, ажлын гүйцэтгэгчээр санал ирүүлэхийг хориглоно.”

2/10 дугаар зүйлийн 10.14 дэх хэсэг:

“10.14.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, инженерийн тооцоо, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах, тохируулах, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбогдсон хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг бүхэлд нь хамарсан, эсхүл зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлтэй зохион байгуулж болно.

3/12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэг:

“12.10.Барилгын зураг төсөл, барилгын ажил, зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх техникийн тодорхойлолт барилгын үйл ажиллагаа болон материалтай холбоотой техникийн зохицуулалтад үндэслэсэн байна.”

4/15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг:

“15.7.Энэ хуулийн 54.11-д заасан оноо бүхий салбарын аж ахуй эрхлэгчид тавигдах чадавхын болон туршлагын оноог тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.”

5/31 дүгээр зүйлийн 31.1.5 дахь заалт:

“31.1.5.чадавхад суурилсан хэлэлцээ.”

6/31 дүгээр зүйлийн 31.5, 31.6 дахь хэсэг:

“31.5.Тендер шалгаруулалтыг тухайн аргаар хоёроос доошгүй удаа зарлахад нэг ч тендер ирээгүй бол төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл өмчийн оролцоотой хуулийн этгээдээр тухайн худалдан авах бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгүүлж болно.

31.6.Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хоёроос доошгүй удаа тендер шалгаруулалт зарлахад энэ хуулийн 26.9-д заасан шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй бөгөөд тендер шалгаруулалтыг дахин зарлах бол энэ хуулийн 32.3-т заасан хугацааг ажлын таваас доошгүй өдрөөр зааж болно.”

7/36¹ дүгээр зүйл:

“36¹ дүгээр зүйл.Чадавхад суурилсан хэлэлцээний арга

36¹.1.Бараа, ажил, үйлчилгээний цар хүрээ, төсөвт өртөг өндөр, хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг цогцоор нь гүйцэтгэх шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай аж ахуй эрхлэгчийн тоо хязгаарлагдмал тохиолдолд гүйцэтгэгчийг энэ зүйлд заасан аргаар сонгож болно.

36¹.2.Энэ хуулийн 36¹.1-д заасан төсөл, арга хэмжээнд дараах үе шатыг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тогтоож болно:

36¹.2.1.төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх анхан шатны судалгаа, техникийн тодорхойлолт боловсруулах;

36¹.2.2.гэрээний хэрэгжилтэд захиалагчийн нэрийн өмнөөс хяналт хэрэгжүүлэх, төслийн менежментийн үйлчилгээ үзүүлэх;

36¹.2.3.энэ хуулийн 10.14-т заасан нөхцөлтэй ажил;

36¹.2.4.захиалагчийн шаардлагатай гэж үзсэн бусад.

36¹.3.Захиалагч чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад оролцох чадавх бүхий аж ахуй эрхлэгчийг төсөл, арга хэмжээний зорилго, цар хүрээ, хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэрэгт үндэслэн тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх урилгыг аж ахуй эрхлэгчид хүргүүлнэ.

36¹.4.Чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх мэдэгдэл, тендер ирүүлэх, хэлэлцээ ирүүлэх журмыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

36¹.5.Энэ хуулийн 36¹.1-д заасан төсөл, арга хэмжээний цар хүрээ, онцлогийг харгалзан тендер шалгаруулалтын баримт бичигт дараах болон бусад нөхцөлийг энэ хуульд зааснаас өөрөөр зааж болно:

36¹.5.1.тендер, тендерийн баталгааг цахимаар, эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авах;

36¹.5.2.тендер шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах хэлийг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг гадаад хэл байх.

36¹.6.Хэлэлцээний шатанд дараах нөхцөлийг оролцогчтой харилцан тохиролцож болно:

36¹.6.1.тендерийн үнэ, гэрээний үнэ, төлбөр тооцоо гүйцэтгэх валют;

36¹.6.2.олон улсад өргөн хэрэглэгддэг худалдан авах гэрээний нөхцөл, маргаан шийдвэрлэх журам;

36¹.6.3.худалдан авах гэрээний бусад нөхцөл.

36¹.7.Захиалагч оролцогчтой хэлэлцээ хийх ажлын хэсгийг томилон ажиллуулна.

36¹.8.Энэ хуулийн 36¹.2.2, 36¹.2.3-т заасан гүйцэтгэгч харилцан хамааралтай байхыг хориглоно.

36¹.9.Энэ зүйлийн 36¹.1-д заасан жагсаалтыг тендер шалгаруулалтыг зохион байгуулах этгээдийн хамт Засгийн газар батална.

36¹.10.Чадавх бүхий аж ахуй эрхлэгчээр энэ хуулийн 36¹.2.1-д заасан үе шатыг шууд сонгон гүйцэтгүүлж болно.”

8/37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг:

“37.8.Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ерөнхий гэрээний аргын нэгдүгээр үе шатны тендер шалгаруулалтад энэ хуулийн 37.4-т заасан хянан үзэх ажиллагаанд оролцогчийн эм, эмнэлгийн хэрэгсэлд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан аргачлалаар чанарыг хянан үзэж, оноо өгнө.”

9/38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг:

“38.8.Энэ хуулийн 38.4-т заасан үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад гүйцэтгэгчийн ирүүлсэн эцсийн үнийн санал, энэ хуулийн 37.8-д заасан оноог тендер шалгаруулалтын баримт бичигт заасан аргачлалын дагуу тооцож, үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноотой эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн гүйцэтгэгчтэй захиалагч гэрээ байгуулна.”

10/48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсэг:

“48.9.Хуулийн 36¹.9-д заасан жагсаалтад багтсан төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг санхүүжилтийн эх үүсвэр батлагдахаас өмнө эхлүүлж болно.”

11/49 дүгээр зүйлийн 49.10 дахь хэсэг:

“49.10.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр санхүүжүүлэх 10 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй нийгмийн болон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.”

12/54 дүгээр зүйлийн 54.11, 54.12 дахь хэсэг:

“54.11.Барилга, эрчим хүч, автозам, төмөр зам, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцийн салбарын зөвшөөрөл эзэмшигчийн чадавхын болон туршлагын оноог салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбоо хамтран тогтооно.

54.12.Энэ хуулийн 54.11-д заасан аж ахуй эрхлэгчийн чадавхын болон туршлагын оноо олгох журмыг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.7 дахь заалтын “Төрийн аудитын” гэсний өмнө “Засгийн газраас хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хувь хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн болон” гэж, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн “төсвийн” гэсний өмнө “болон орон нутгийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалт:

“36.1.3.нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан бараа, үйлчилгээний анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх үед гүйцэтгэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;”

2/49 дүгээр зүйлийн 49.9 дэх хэсэг:

“49.9.Гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.”

4 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн “26.4.2, 26.4.3-т” гэснийг “26.4-т” гэж, 26.9 дэх хэсгийн “Тендер шалгаруулалтын” гэснийг “Энэ хуулийн 26.7-д өөрөөр заагаагүй бол тендер шалгаруулалтын” гэж, 34 дүгээр зүйлийн 34.12 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “байна.” гэснийг “байж болно.” гэж, 51 дүгээр зүйлийн 51.5 дахь хэсгийн “түүнтэй адилтгах бусад нөхцөл байдлаас шалтгаалан” гэснийг “хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Төрийн болон орон нутгийн өмчийн
хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан
 авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
хуулийн төслийн талаар*

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тендер шалгаруулалттай холбоотой зохицуулалт тусгагдсан тул тус хууль хүчин төгөлдөр болохоос өмнө зарласан тендер шалгаруулалтыг нэмэлт, өөрчлөлт орохын өмнөх зохицуулалтын дагуу зохион байгуулж дуусгах тухай харилцааг зохицуулсан.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг болон 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага буюу худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нэмэгдүүлэх агуулга тусгагдсан бөгөөд уг чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон бусад бэлтгэл ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хангах боломжтой тул тус зохицуулалтын хэрэгжих хугацааг өөрөөр заасан. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 болон 12 дахь хэсэгт мэргэжлийн нэгдсэн холбоодтой холбоотой зохицуулалт орсон тул Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөх 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөртэй уялдуулан үйлчлэх хугацааг тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА,
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө зарласан тендер шалгаруулалтыг нэмэлт, өөрчлөлт орохын өмнөх зохицуулалтын дагуу зохион байгуулж дуусгана.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг болон 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, 1 дүгээр зүйлийн 4 болон 12 дахь хэсгийг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагалдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл мөн өдөр батлагдсан.

Уг хуулиар нийслэл хотын хот тохижилт, авто зам, халаалт, цэвэр, бохир усны шугам, үерийн далан сувгийн засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээ зэрэг нийслэл хотын хотын аж ахуй, инженер хангамжийн бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх боломжтой болсон.

Дээрх хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болох өдрөөс буюу 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Гэтэл гамшиг, осолд хамаарахгүй бөгөөд бороо, үеийн нөхцөл байдал болон бусад шалтгаанаар хойшлуулшгүй сэргээн босголтын ажлыг гүйцэтгэх, хотын аж ахуй, инженерийн хангамжийн төлөвлөгөөт бус бараа, ажил, үйлчилгээ нэмэлтээр худалдан авах шаардлага төсөвт жилийн дундуур үүсээд байна.

Иймд хотын хот тохижилт, авто зам, халаалт, цэвэр, бохир усны шугам, үерийн далан сувгийн засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээ зэрэг нийслэл хотын хотын аж ахуй, инженер хангамжийн бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх боломжийг нэн даруй бүрдүүлэх зорилгоор Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацааг баримталсан дээрх хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл батлагдсанаар нийслэл Улаанбаатар хот цахилгаан, дулаан, усаар тасрахгүй хэвийн байх, үер ус, бохирдол, хог хаягдал, ногоон байгууламж зэрэг хотын аж ахуйн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх тусгай чиг үүргийн байгууллагууд гамшигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хотын аж ахуйн үйл ажиллагаа хэвийн тасралтгүй үргэлжлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах амьдралын чанар хангагдана гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА,
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар*

Хувийн хэвшил нийгмийн хариуцлагын хүрээнд байгалийн нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, зохистой ашиглах, цөлжилтийг сааруулах, орчны бохирдлыг бууруулах, соёлын өвийг хамгаалах, сэргээх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, хамгааллын үйл ажиллагаа явуулах, боловсрол, шинжлэх ухааныг дэмжих чиглэлээр тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг олгох, биеийн тамир, спортын барилга байгууламж барьж ашиглах зэрэг нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийг өөрийн хөрөнгөөр санаачлан хэрэгжүүлж, төрийн үүрэх ачааллыг хуваалцаж байгааг татварын бодлогоор дэмжих нь зүйтэй байна.

Иймд хуулийн төсөлд заасан чиглэл, зориулалтаар нийгмийн хариуцлагын хүрээнд албан татвар төлөгч нь элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт болон харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогын 1 хувиас хэтрэхгүй дүнгээр үйл ажиллагааны орлогод төлбөл зохих албан татвараас хасаж хөнгөлөхөөр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар хувийн хэвшил өөрийн санаачилга, хөрөнгөөр нийгмийн хариуцлагын хүрээнд бодитой бүтээн байгуулалт, төсөл хэрэгжүүлэхэд татварын хөнгөлөлт эдэлж, нийгэмд хувь нэмрээ оруулах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэн урамшуулж эдийн засаг, нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж, төсвийн ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.9-22.13 дахь хэсэг нэмсүгэй:

“22.9.Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээгээр хасаж хөнгөлнө:

22.9.1.ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах;

22.9.2.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах;

22.9.3.соёлын өвийг хамгаалах, сэргээх, музей, номын сангийн үйл ажиллагаа болон хөгжим, кино, дуу-дүрс, дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг, гар урлал, тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах, ашиглах;

22.9.4.нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн /парк/ барьж байгуулах, ашиглах, хамгаалах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх, нийтийн тээврийн хөгжлийг дэмжих;

22.9.5.давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас хохирол барагдуулах;

22.9.6.спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах;

22.9.7.өөрийн ажилтнаас бусад оюутан, сурагчид олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэг;

22.9.8.их, дээд сургууль, шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэг;

22.9.9.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагаа;

22.9.10.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа;

22.9.11.Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа.

22.10.Энэ хуулийн 22.9.1-д заасан нөхөн сэргээх зардалд энэ хуулийн 13.4, 22.5.9-д зааснаас бусад нөхөн сэргээх зардал хамаарна.

22.11.Энэ хуулийн 22.9-д заасны дагуу хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хяналт тавина.

22.12.Энэ хуулийн 22.9-д заасан хөнгөлөлтөд хамаарах зардал нь энэ хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан шаардлагыг хангасан байна.

22.13.Энэ хуулийн 22.9-д заасан хөнгөлөлтөд хамаарах хөрөнгө оруулалт, зардлыг татварын албанаас баталсан маягтын дагуу энэ хуулийн 26.1, 26.2-т заасан тайланд хавсаргаж тайлагнана.”

2 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалтын “15.1.6, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10-т” гэснийг “22.9-д” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10, 15.1.16, 15.1.17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг 2031 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн анхдугаар чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн баталсан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдаж, зарим яамдын нэр, Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд өөрчлөлт орсон.

Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах асуудал Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудалд шилжсэн тул Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 11^{1.1} дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “боловсролын” гэснийг “цөмийн энергийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар

Улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг үр дагавар болох гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд байгалийн нөөцийн тодорхой хэсэг өртдөг бөгөөд тухайн өртөх хэсгийн байгалийн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийх, байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал үүсдэг. Гэвч энэ төрлийн зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр орон нутгийн төсөвт байдаггүй. Үүнээс үүдэн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, бүс нутаг, салбарын хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын бодлогод туссан зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажил удааширч, гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах боломжийг хязгаарладаг.

Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай хамт баталсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт тусгуулж байх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргад хүлээлгэж, гамшгаас хамгаалах болон гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг уг нөхөн төлбөрөөс чөлөөлөхөөр болсон.

Гэвч дээрх хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болох өдрөөс буюу 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр зохицуулсан нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдсэн өнөөгийн нөхцөлд нийслэл Улаанбаатар хотод үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршиг, үр дагавраас урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг нэн даруй хэрэгжүүлэх бодит шаардлагад нийцэхгүй байна.

Иймд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх хугацааг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөх өдрөөс эхлэн дагж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрхлэх ажлыг тодорхойлсон бөгөөд Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг зохицуулахад туслах, хүний нөөцийн удирдлага, нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах асуудлыг эрхлэн гүйцэтгэдэг.

Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хяналт тавих ажиллагааг Засгийн газар дахь хяналтын тухай хуулиар зохицуулж байгаа боловч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг болон Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг нэгтгэж, Засгийн газарт оруулах чиг үүрэг тодорхойгүй байна.

Түүнчлэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилго, зорилт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх нэгж нь буюу хяналт-шинжилгээ хийсний үндсэн дээр үнэлэлт дүгнэлт хийх, энэ чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын баримт, бичиг болон тогтоол, шийдвэрийн биелэлтийг нэгтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, танилцуулах болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан гүйцэтгэхээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 13, 14 дэх заалт нэмсүгэй:

“13/Бодлогын баримт бичгийн биелэлт, гүйцэтгэлийг улсын хэмжээнд нэгтгэн тооцож, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ;

14/Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Энэхүү хууль нь 9 бүлэг 60 зүйлтэй анхдагч хууль бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийн шинэ харилцааг нарийвчлан зохицуулахыг зорьж, олон улсын жишигт нийцүүлэн дэд бүтцийн төслүүд, төрийн үйлчилгээг хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг татан, түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллаж хэрэгжүүлэх, төсвийн ачааллыг бууруулах боломжийг бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх өндөр ач холбогдолтой.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг урт хугацааны туршид хувийн хэвшлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь төслийг тодорхойлох, төслийн санал гаргах, урьдчилсан үнэлгээ хийх, түүнийг хянан баталгаажуулах, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, бүрэн шинжилгээ хийх, түүнийг хянах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, сонгон шалгаруулалт зохион байгуулах, хэлэлцээр хийх, гэрээ байгуулах эрх олгох эсэхийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, гэрээ байгуулах, хэрэгжүүлэх зэрэгт багагүй цаг хугацаа, олон байгууллагуудын оролцоо, хүн хүч, санхүүгийн эх үүсвэр, судалгаа тооцоо шаардсан үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан. Хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой холбогдох байгууллагуудын санал, төслийн саналыг хүлээн авч үнэлэх, түншлэлийн төслийн бэлтгэл ажлыг хангаж, хуулийг хэрэгжүүлэх явцад зарим хуулийн хэсэг, заалтууд хоорондын уялдаа холбоо алдагдсан, нэр томьёоны тайлбар дутмаг, оролцогч байгууллагуудын чиг үүрэг нь давхардсан болон тодорхойгүй зэрэг асуудлууд үүсээд байна. Иймээс хуулийн зарим зүйл, заалтын уялдаа холбоог сайжруулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, нэр томьёо хэрэглээг ойлгомжтой болгох, хөгжлийн томоохон төслүүдийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулах хэрэгцээ шаардлагын улмаас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслөөр урьдчилсан үнэлгээ хийхтэй холбоотой үйл ажиллагаа, холбогдох байгууллагын чиг үүргийг ойлгомжтой болгож, бүрэн шинжилгээ болон сонгон шалгаруулалтын зохион байгуулалтыг оновчтой болгосон бөгөөд хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах үйл ажиллагаа, төслийн бэлтгэл ажлын төлбөр, түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хувийн хэвшлийн түншлэгчийн эзэмшилтэй холбоотой зохицуулалтуудыг тодорхой болгож тусгасан.

Түүнчлэн цаг хугацааны хувьд нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлага үүссэн төслүүдийг төрөөс санхүүжүүлэх боломж хомс учраас нийтийн зориулалттай дэд бүтэц,

төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн шалтгаанаар төрөөс санхүүжилт гаргахгүйгээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшилтэй сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж түншлэлийн гэрээ байгуулах шаардлага үүссээр байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу төслийг бэлтгэх, сонгон шалгаруулалт зарлах, түншлэлийн гэрээ байгуулахад хамгийн багадаа 2 жилийн хугацаа зарцуулахаар байгаа тул нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлага үүссэн түншлэлийн төслүүдийг уг хугацаагаар явуулах нь цаг хугацааны хувьд боломжгүй байдал үүсгэж байгаа болно.

Иймд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн тохиолдолд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр төслийг хэрэгжүүлэх чадвартай хоёроос доошгүй хувийн хэвшлийн түншлэгчид урилга хүргүүлж, төслийн санал авч, хэлэлцээ хийж, хамгийн сайн нөхцөл санал болгосон түншлэгчтэй гэрээ байгуулах боломжийг нэмэлтээр тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалт:

“37.1.3.нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан аргаар төслийг зарлаж, сонгон шалгаруулах хугацааг мөрдөх боломжгүй.”

2/37 дугаар зүйлийн 37.7-37.11 дэх хэсэг:

“37.7.Энэ хуулийн 37.1.3-т заасан аймаг, нийслэлийн болон 2-оос дээш аймгийн нутаг дэвсгэр дамжин хэрэгжих түншлэлийн төслийг Засгийн газар хэрэгжүүлнэ.

37.8.Засгийн газар энэ хуулийн 37.7-д заасан бүрэн эрхээ аймаг, нийслэлд шилжүүлж болно.

37.9.Энэ хуулийн 37.7-д заасан түншлэлийн төслийн хэлэлцээг хийх, гэрээ байгуулах асуудлыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулах ба дараах журмыг баримтална:

37.9.1.хэлэлцээ хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах;

37.9.2.төслийг хэрэгжүүлэх 2-оос доошгүй хувийн хэвшлийн түншлэгчид төслийн санал ирүүлэх урилга хүргүүлэх;

37.9.3.хувийн хэвшлийн түншлэгчээс төслийн санал хүлээн авах;

37.9.4.төслийн санал ирүүлсэн хувийн хэвшлийн түншлэгчтэй хэлэлцээ хийх;

37.9.5.хамгийн сайн нөхцөл санал болгосон хувийн хэвшлийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гаргах;

37.9.6.энэ хуулийн 37.9.5-д заасан дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлж, түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл авах;

37.9.7.түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга хамтран түншлэлийн гэрээ байгуулах, энэ хуульд заасан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих.”

37.10.Энэ хуулийн 37.8-д заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэгч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

37.11.Аймаг, нийслэлийн Засаг дарга хэлэлцээ хийж гэрээ байгуулахад энэ хуулийн 13.3-т заасан журмаас гадна дараах журмыг баримтална:

37.11.1.хэлэлцээ хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах;

37.11.2.төслийг хэрэгжүүлэх 2-оос доошгүй хувийн хэвшлийн түншлэгчид төслийн санал ирүүлэх урилга хүргүүлэх;

37.11.3.хувийн хэвшлийн түншлэгчээс төслийн санал хүлээн авах;

37.11.4.төслийн санал ирүүлсэн хувийн хэвшлийн түншлэгчтэй хэлэлцээ хийх;

37.11.5.хамгийн сайн нөхцөл санал болгосон хувийн хэвшлийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гаргах;

37.11.6.энэ хуулийн 37.11.5-д заасан дүгнэлтийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлж, түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл авах;

37.11.7.түншлэлийн гэрээ байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих.”

3/50 дугаар зүйлийн 50.8 дахь хэсэг:

“50.8.Түншлэлийн төслийн бэлтгэл ажлын төлбөрийг түншлэлийн гэрээнд заасны дагуу санд төвлөрүүлнэ.”

2 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг:

“20.3.Энэ хуулийн 20.2-т заасан төслийн багийн бүрэлдэхүүнд түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн төслөөс хамааран холбогдох төрийн байгууллага, төсөл хэрэгжих аймаг, нийслэлийн төлөөлөл байх бөгөөд шаардлагатай бол төслийн багийн бүрэлдэхүүнд санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын

үндэсний, олон улсын мэргэжлийн судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөх гишүүн оруулж болно.”

2/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөндлөнгийн хараат бус гишүүн оруулж болно.”

3/37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг:

“37.2.Энэ хуулийн 37.1.1, 37.1.2-т заасан саналыг түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх бөгөөд гэрээ байгуулах асуудлыг энэ хуулийн 7.2.3, 37.9-д заасан журмаар зохицуулна.”

3 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “үнэлэх” гэснийг “урьдчилсан үнэлгээ хийх” гэж, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “2 сараас” гэснийг “1 сараас” гэж, 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсгийн “37.1-д” гэснийг “37.1.1, 37.1.2-т” гэж, 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн “байхыг хориглоно” гэснийг “байж болно” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “түншлэлээр хэрэгжүүлэхээр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “болон санхүү, төсвийн” гэснийг, 19.5 дахь хэсгийн “, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Түншлэлээр хэрэгжүүлэхээр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төсөлд” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг
дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт
оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэн.

Засгийн газрын 2022 оны 309, 2023 оны 253, 355, 379 дүгээр тогтоолуудаар Зам, тээврийн салбарт хэрэгжих “Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төсөл”, “Рашаант-Хөшигийн хөндий-Хоолт зөрлөг” чиглэлийн 4 эгнээ, “Налайх-Багахангай-Чойр-Сайншанд-Замын-Үүд” чиглэлийн 2 эгнээ тусгай зориулалтын авто зам барих төсөл”, “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг “Туулын авто зам” төсөл”, “Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох Наадамчдын гудамжны авто зам дээгүүр барих 800 у/м гүүрэн байгууламжийн төсөл”, “Хөвсгөл аймгийн “Мөрөн” нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төсөл”, “Ховд аймгийн “Ховд” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4С ангиллын болгох төсөл”, “Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4С ангиллын болгох төсөл”, “Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4D ангиллын болгох төсөл”-үүдийн концессын төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгасан. Мөн Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 35 дугаар тэмдэглэлээр Концессын тухай хуулийн дагуу концессын төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, шууд гэрээ байгуулах дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж, дүнг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж ажиллахыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас эдгээр төслүүдийн концессын уралдаант шалгаруулалтыг Концессын тухай хуулийн хүрээнд зарласан ба эдгээр төсөл хөтөлбөрүүд нь агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоо болон авто замын хүчин чадал, нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх, гадаад дотоод худалдаа, экспортыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх болон нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад өндөр ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүд болно. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснээр Концессын тухай хуулийн дагуу зарласан уралдаант шалгаруулалтыг үргэлжлүүлэх эсэх болон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах асуудлыг аль хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх талаар эрх зүйн зохицуулалтгүй байх тул ойлгомжгүй нөхцөлийг үүсгэхээр байна. Концессын тухай хуулийн дагуу зарласан дээрх улсын хэмжээний томоохон төсөл, арга хэмжээнүүдийн уралдаант шалгаруулалт үргэлжилж

байх хугацаанд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль үйлчилж эхэлснээр эдгээр төсөл, арга хэмжээнүүдэд уралдаант шалгаруулалтыг дахин зарлаж, өмнөх уралдаант шалгаруулалт үр дүнгүй болохоор байна. Тиймээс төсөл, арга хэмжээнүүдийн уралдаант шалгаруулалтыг дахин зохион байгуулснаар цаг хугацаа алдаж, эдийн засгийн хувьд үр ашиггүй байдалд хүргэх ба хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгээр дэвшүүлсэн дараах зорилтод хүрэхэд хүндрэл бэрхшээл үүсэхээр байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад зааснаар Концессын тухай хуулийн хүрээнд уралдаант шалгаруулалт зарлагдсан дээрх төслүүдэд тухайн хуулийн дагуу сонгон шалгаруулалт, гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалтууд нь үйлчлэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 7¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“7¹ дүгээр зүйл.Энэ хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө Төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт зарласан тохиолдолд шалгарсан этгээдтэй Концессын тухай хуулийн дагуу концессын гэрээ, дагалдах гэрээг байгуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Засгийн газар дахь хяналтын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын албан тушаал нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарахаар заасныг хүчингүй болгож, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байхаар зохион байгуулсан өөрчлөлт нь Засгийн газраас харьяа яам, агентлаг, тэдгээрийн албан тушаалтны хууль болон албаны чиг үүргээ хэрэгжүүлэх байдалд сөргөөр нөлөөлөх, зохих хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй болоход хүргэж байх тул Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсын Засгийн газрын оновчтой, үр ашигтай засаглалыг бэхжүүлэх, Засгийн газрын харьяа байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаа, албаны чиг үүргээ хууль тогтоомжийн хүрээнд явуулж байгаа эсэх, чиг үүргээ бүрэн, хуульд зааснаар хэрэгжүүлж байгаа эсэх, төрийн үйлчилгээг хүнд суртал, дарамтгүй үзүүлж буй эсэхэд Засгийн газрын хяналтын байгууллага шууд хяналт тавих, алдаа дутагдал, хуулийн зөрчлийг таслан зогсоох, хуулийн дагуу хариуцлага тооцох шуурхай, илүү үр дүнтэй тогтолцоо бүрдэх юм.

--o0o--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗАР ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.7 дахь хэсэг нэмсүгэй:

“16.7.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын албан тушаал нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарна.”

2 дугаар зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтын “үзүүлэх” гэсний дараа “, үйл ажиллагаанд нь хяналт тавих, зохицуулах” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн дугаарыг “16.8” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Төрийн хяналт шалгалтын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн анхдугаар чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн баталсан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдаж, Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд өөрчлөлт орсон.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын эрхлэх асуудалд шилжсэн тул Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

--o0o--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1} дэх хэсгийн “Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт” гэснийг “Хяналт, үнэлгээний үндэсний хороонд” гэж, 5^{1.2} дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Хяналт, үнэлгээний үндэсний хороо” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай
Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар*

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” болон “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 23 дугаар тогтоолоор “Тавантолгой түлш” ХХК байгуулагдсан. Засгийн газрын 2021 оны 316 дугаар тогтоолын дагуу тус компанийн хувьцааг хуваарилсан ба хувьцааны 51 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 39 хувийг Эрчим хүчний яам, 10 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж байна. Тус компани нийслэлийн 7 дүүрэгт 650 борлуулалтын цэгээр борлуулалтын үйл ажиллагааг явуулж, 200 мянга гаруй айл өрхөд 2018 оноос хойш нийт 2.5 сая тонн түлшийг борлуулсан байна.

Шахмал түлшний чанар, стандарт, хэрэглээнд Эрчим хүчний яам, Хими, химийн технологийн хүрээлэн, Ашигт малтмал, газрын тосны газар, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Эрүүл мэндийн яамны зүгээс хяналт тавьж хамтран ажилладаг бөгөөд хүйтний улирлын агаарын чанарын гол үзүүлэлт болох PM2.5, PM10 тоосонцрын хэмжээ 43-56%-иар буурсан үр дүнг үзүүлсэн.

Түүнчлэн, тайлант оны эхний хагас жилийн байдлаар нийт урт хугацаат өр төлбөр буюу “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас авсан санхүүжилт 1,242 тэрбум төгрөг, нийт хөрөнгийн дүн 468.6 тэрбум төгрөг байгаагаас эргэлтийн хөрөнгө 178.9 тэрбум, эргэлтийн бус хөрөнгө 289.7 тэрбум төгрөг, хуримтлагдсан алдагдал 790.3 тэрбум төгрөг тус тус байна.

